**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ**
**2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ**

2018.12.05. Шивээговь сум

| № | Дунд хугацааны зорилт | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Шаардагдах хөрөнгө, эх үүсвэр /сая.төг/ | Арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах** | | | | | | | | |
| **1.1.Санхүү, төсвийн бодлогын чиглэлээр** | | | | | | | | |
| 1 | Төсвийн сахилга батыг сайжруулж, үр ашиггүй зардлыг багасган, хэмнэлтийг эрхэмлэнэ. | Төсвийн сахилга бат, санхүүгийн хяналтын үр дүнг сайжруулна. | Холбоотой зөрчил гараагүй байна. | 100 хувь | - | 1. Сумын төсвийн байгууллагууд улирал бүрийн дараа сарын 10-ны дотор Засгийн газрын 147 дугаар тогтоолын биелэлтийг гаргаж аймагт хүргүүлэх. Улсын их хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах<br>2. Төсвийн хэтрэлт хэмнэлтийн мэдээллийг цахим болон мэдээллийн самбарт ил тод мэдээлэх.<br>3. Санхүүгийн сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд улирал бүр сонгогдсон нэг байгууллагын санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийж Төсвийн ерөнхийлөн захирагчид танилцуулах.<br>4. Орон нутгийн орлогын тайланг аймгийн татварын хэлтэст, Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэх<br>5. Авлага, өр төлбөрийн талаар улирал бүр харилцагч байгууллагуудтай тооцоо нийлэн баталгаажуулах, шинээр үүсгэхгүй байх талаар ажиллах. | 1. Засгийн газрын 147-р тогтоолын биелэлтийг улирал бүр тайлагнан 3 дугаар улирлын байдлаар хэмнэлт-41194,6 мянган төгрөг, хэтрэлт-21801,5 мянган төгрөг бөгөөд 94,5 хувийн хэрэгжилттэй байна. Улсын их хурлын 2016 оны 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган санхүү, төсвийн мэдээллүүдийг шилэн данс болон мэдээллийн самбарт сар бүрийн 10-ны дотор байршуулан ажиллаж байна.<br>2. Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн мэдээг санхүүгийн мэдээллийн самбарт сар бүрийн 10-ны дотор, цахим болон шилэн дансанд сар бүрийн 8-ны дотор байршуулан ажиллаж байна.<br>3. Сумын бүх төсвийн байгууллагын санхүүгийн баримтанд 2 удаа хяналт хийж арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажилласан.<br>4. Орон нутгийн орлогын тайланг сар бүрийн 02- ны дотор цахимаар болон цаасаар хүргүүлэн ажиллаж байна.<br>5. Төсвийн байгууллагууд нийт 50626,1 мянган төгрөгийн өглөгтэй байна. Энэ нь цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалд 11107,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, цэвэр усны үнэ 4 дахин нэмэгдэж 9544,3 мянган төгрөг, суманд 1-р сард шүлхий өвчин гарсантай холбогдуулан 1550,0 мянган төгрөгийн шатхууны өглөгүүд үүссэн байна. | 100 |
| 2 | | Орон нутгийн хөгжил санг иргэдэд ил тод нээлттэй | - ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын | - 53 хувь | - | 1. 2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг батлагдсан саналын хуудсаар сумын нийт өрхийн 55 | 1. 2019 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналыг багийн Засаг дарга нар батлагдсан маягтын дагуу 957 өрх буюу сумын нийт өрхийн 89,6 хувиас авч урьдчилсан жагсаалт бэлтгэн 1, 2-р | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | байлгаж зарцуулалтын үр дүнг дээшлүүлнэ | ажлын санал авахад оролцсон нийт өрхийн эзлэх хувь | | | хувиас авах<br>2. ОНХС-ийн мэдээ, тайланг иргэдэд тайлагнаж бүх нөхцөлөөр ил тод мэдээлэх | БИНХ-аар хэлэлцүүлэн Засаг даргын 2018 оны А\47 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэгт хүлээлгэн өгөөд байна.<br>2. ОНХС-ийн хөрөнгө зарцуулалтын мэдээг сар бүр шилэн данс, цахим худалдан авах ажиллагааны www.tender.mn сайт, сумын цахим сайтад тухай бүр байршуулж, ЗДТГ-ын хөрөнгө оруулалтын мэдээллийн самбаруудаар байршуулан иргэдэд ил тод мэдээлэн ажиллаж байна. Мөн 1, 2-р багийн иргэдийн нийтийн хурлаар иргэдэд 2017 оны орон нутгийн хөгжлийн сангийн **171 270 999** төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн 16 ажлын тайлан болон 2018 онд **173,177,800** төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа 21 ажлын танилцуулгыг хүргэн ажилласан. | 70 |
| 3 | | Орон нутгийн хөгжил сангийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг бүртгэлжүүлэх | - Хөрөнгө эзэнжсэн байна. | - 100 хувь | - | 1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын жагсаалт гаргаж хариуцах байгууллагыг тодорхойлон ОНӨҮГ-т хүргүүлж бүртгэлжүүлэх | 1. 2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт бүртгэлжүүлэх саналыг хүргүүлсний дагуу 10 хөрөнгийг холбогдох байгууллагуудын үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд бүртгэлжүүлсэн. 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн жагсаалтыг гаргаж хариуцан байгууллагыг тодорхойлон ОНӨҮГ-т хүргүүлсэн. | 100 |
| 4 | | 2019 оны Сумын орон нутгийн хөгжлийн санг хуулийн хүрээнд төлөвлөж, Сумын ИТХ-аар батлуулах. | - Багийн өрхүүдээс саналын хуудсаар санал авах<br>- Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийг иргэдээр хэлэлцүүлж, эрэмбэлэх<br>- Хууль, журмын дагуу төлөвлөх. | - Төсвийн тухай хууль , ОНХС-ийн санг төлөвлөх, зарцуулах журамд нийцсэн байна.<br>- Сумын ИТХ-аар батлуулсан байна. | БТ | 1. Багийн өрхүүдээс 2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг саналын хуудсаар авах<br>2. Багийн Иргэдийн нийтийн хурлаар 2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг эрэмбэлүүлж сумын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг саналыг нэгтгэн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ИТХ-д хүргүүлэх | 1. 2019 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналыг багийн Засаг дарга нар батлагдсан маягтын дагуу 957 өрх буюу сумын нийт өрхийн 89,6 хувиас авсан.<br>2. 2019 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын урьдчилсан жагсаалтыг бэлтгэн 1, 2-р БИНХ-аар хэлэлцүүлэн Засаг даргын 2018 оны А\47 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг зааврын дагуу эрэмбэлж, сумын ИТХ-д хүргүүлсэн. | 100 |
| 5 | | 2018 оны ОНХСангийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Худалдан авах ажиллагааны хууль | - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх<br>- үр дүнг олон нийтэд 2-оос доошгүй удаа | - Худалдан авах ажиллагааны журмыг баримтласан байна.<br>- Зориула | БТ | 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гарган сумын Засаг даргаар батлуулж, төлөвлөгөөг олон нийтэд мэдээлэх<br>2. Худалдан авах ажиллагааны журмыг баримтлан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | 1. Сумын 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 21 ажил, арга хэмжээг 173177800 төгрөгөөр хэрэгжүүлэхээр сумын Засаг даргаар хугацаанд нь батлуулан Tender.gov.mn, shiveegovi.gov.mn цахим хуудаст байршуулсан.<br>2. Сумын 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлуудыг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжийн хүрээнд, зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг олон нийтэд тайлагнах | тайлагнах | лтын дагуу зарцуулсан байна. - Өр, авлага үүсгээгүй байна. | | 3. Худалдан авах ажиллагааны тайлан, мэдээ гаргах | холбогдох журмын дагуу зохион байгуулж нийт 21 ажлыг төлөвлөснөөс 20 ажлыг зохион байгуулан хяналт тавин ажиллаж, гүйцэтгэгч талын хариуцлагагүйгээс 1 ажлын гэрээ цуцлагдаад байна. 3. Худалдан авах ажиллагааны тайланг холбогдох журмын дагуу сар бүр гарган аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэн байгууллагын мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. | |
| 6 | | Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулна. | Цахимаар зохион байгуулсан худалдан авалт | 100 хувь | - | 1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 3 ажлыг цахимаар зарлах, хэрэгжилтийг хангаж ажиллах | 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 3 ажилд тендер зарлан ажиллахаар төлөвлөгдсөний дагуу 2 тендрийг цахимаар зарлаж, эрүүл мэндийн төвд 4D эхо аппарат авах цахим тендерийг 2 удаа зарласан боловч амжилтгүй болж, захиалагчтай шууд гэрээ байгуулж худалдан авсан. Тендерийн урилга, шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх мэдээллийг сумын вэб сайт болон мэдээллийн самбарт байршуулж иргэдэд ил тод мэдээлэж ажилласан. | 70 |
| 7 | | Сумын татвар төлөгчдийн хүрээг өргөжүүлэн, татварын орлогыг нэмэгдүүлж, орон нутгийн орлогыг бүрдүүлнэ. | - Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөний биелэлт | - 100 хувь | - | 1.Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлагнах | 2018 оны 11-р сарын байдлаар Орон нутгийн татварын орлого 53055200 төгрөг төвлөрөхөөс гүйцэтгэлээр 51454044 төгрөг төвлөрч биелэлт 97 хувийн хэрэгжилттэй байна. | 100 |
| 8 | | Хүн, малын тооллого болон хүн ам, орон сууцны 2018 оны завсрын тооллогыг зохион байгуулах | - Хүн, малын тооллогын тоо - Хүн ам, орон сууцны 2018 оны завсрын тооллогын тоо | - 2 - 1 - Тооллого товлосон хугацаанд аргачлал, заавар, журмын дагуу чанартай хийгдэж тайлан мэдээ хугацаанд | БТ | 1. Жилийн эцсийн хүн ам, мал тооллого болон хагас жилийн малын түүвэр судалгааны ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар томилох 2. Тооллогын тоологч нарт сургалт зохион байгуулах 3. Тооллогын ажлыг чанартай зохион байгуулж мэдээ, тайлан, судалгаа хугацаанд нь батлагдсан маягтын дагуу гаргаж аймгийн Статистикийн хэлтэст хүргүүлэх | Сумын Засаг даргын А/84 Захирамжаар хагас жилийн малын түүвэр судалгааг зохион байгуулах ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж малын түүвэр судалгаанд 1, 2 дугаар багийн малчин болон мал бүхий 30 өрхийн 18227 толгой малыг тооллогод бүрэн хамруулж мэдээ тайланг аймгийн Стастистикийн газарт хугацаанд нь хүргүүлсэн. Тооллогод адуу-508, үхэр-645, тэмээ-137, хонь-8790, ямаа-8147 тус тус хамрагдсан байна. Сумын засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/177 захирамжаар “2018 оны жилийн эцсийн тооллого”-ын ажлыг зохион байгуулах комиссыг 23 хүний бүрэлдэхүүнтэй томилон тооллогын | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | аа тушаагдсан байна. | | | ажлыг эхлүүлээд байна. Тус ажлыг зохион байгуулах комиссийн 5 хүнийг статистикийн хэлтэсээс зохион байгуулсан "Бүртгэлийн ажилтаны зөвлөгөөн", мал тооллогын "Семинар"-т хамруулсан. | |
| 9 | | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаанд хамрагдах өрхийн жагсаалтыг түүвэрлэлтээр сонгогдсон багаас хугацаанд нь гаргаж, судалгаа явуулахад болон Улсын хэмжээний түүвэр судалгаанд хамтарч ажиллана. | - Судалгаанд сонгогдсон бүх өрхийг хамруулсан байна.<br>- Батлагдсан аргачлал, заавар, журмыг мөрдөж чанартай хийж гүйцэтгэсэн байна. | - Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаанд хамтран ажилласан байна.<br>- Ажлын уялдаа холбоо сайжирсан байна. | - | 1. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаанд хамрагдах өрхийн судалгааг гарган Статистикийн хэлтэст хүргүүлэх.<br>2. Түүврээр сонгогдсон өрхийг судалгаанд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах<br>3. Судалгаанд түүвэрлэлтээр ирсэн өрхийн хаягийг тодорхойлж хөтөчөөр явж хамтран ажиллана. | 1. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа ажиллах хүчний судалгаанд хамрагдах өрхийн судалгааг гарган Статистикийн хэлтэст хүргүүлсэн .<br>2. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд 28 өрх, ажиллах хүчний судалгаанд 24 өрх түүврээр сонгогдсон бөгөөд бүх өрх судалгаанд бүрэн хамрагдсан.<br>3. Багийн засаг дарга нар өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгаанд хамрагдсан өрхүүдэд судалгаа авахаас 3-7 хоногийн өмнө мэдэгдэж судалгааны мэргэжилтэнтэй хамтран ажиллаж өрхүүдийг судалгаанд бүрэн хамруулсан. | 100 |
| 10 | Бизнесийн таатай орчин бүрдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ. | Шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд тусгай зөвшөөрлийг олгож, хяналт шалгалтын давхардлыг багасгаж зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | Хуулийн шаардлага хангасан аж ахуйн нэгжүүдэд олгосон зөвшөөрөл | 100 хувь | - | 1. Тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг иргэдээс хүлээн авч, шаардлага хангасан материалыг сумын ЗДЗ-ийн хуралд танилцуулж, тусгай зөвшөөрөл олгох захирамж гаргуулах<br>2. ААН болон худалдаа үйлчилгээ эрхлэж байгаа иргэд, МЭН-ийн үйл ажиллагаанд улиралд нэг удаа хяналт тавьж, үр дүнг удирдлагад танилцуулах | 1. 2018 онд тамхины тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан 1 ААН, архины тусгай зөвшөөрлийн хугацаа нь дууссан 3 аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулан хяналт тавин ажиллаж байна.<br>2. ААН болон худалдаа үйлчилгээ эрхлэж байгаа иргэд, МЭН-ийн үйл ажиллагаанд аймгийн мэргэжлийн хяналтын газар, ХХААГ-тай хамтран 3 удаа хяналт тавьж, үр дүнг удирдлагад танилцуулан ажилласан. Мөн суманд үйл ажиллагаа ажиллагаа явуулдаг тамхины тусгай зөвшөөрөлтэй 2 ААН, 4 иргэн, архины тусгай зөвшөөрөлтэй 8 аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд цагдаагийн хэсэгтэй хамтран улирал бүр хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 11 | | Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэх аймгийн дэд | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 100 хувь | ОНХС 5.0 | 1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангаж | 1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхээр 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулж | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | | | ажиллах<br><br>2. Сумын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах | хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br><br>2. ЖДҮ эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг дэмжиж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчилах, борлуулах зорилгоор “Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн” үзэсгэлэн худалдааг 2018 оны 09-р сард зохион байгуулж 13 иргэн 6 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож төрөл тус бүрийн ялагчийг тодруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Мөн аймгийн үзэсгэлэн худалдаанд 4 иргэн 3 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр амжилттай оролцсон. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн аймгийн хэмжээний нэгдсэн зөвлөгөөнийг 12-р сарын 14-нд зохион байгуулах бөгөөд сумаас оролцох бэлтгэл ажлыг хангаад байна. | 70 |
| 12 | | ЖДҮДС, СХС-ийн зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ. | Бий болсон байнгын ажлын байрны тоо<br><br>Хуваарийн дагуу төлөгдсөн эргэн төлөлтийн хувь | 25<br><br>70 хувь | ЖДҮДС<br>СХС | 1. 2017 онд зээл олгох тэргүүлэх чиглэлийг боловсруулж, ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах<br>2. Төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хуваарийн дагуу эргэн төлөлтийг 100 хувь төлүүлэх ажлыг зохион байгуулах | 1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг Сумын ИТХ-ын 2018 оны 05 сарын 30-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй томилсон.<br><br>2. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх зорилгоор 2011-2016 онуудад зээл авсан 30 иргэнд зээлийн эргэн төлөлтийг барагдуулах тухай СЗД-ын албан бичиг хүргүүлж 10 иргэнийг шүүхэд өгч 2018 онд төлбөрөө төлж барагдуулахаар тохиролцсон. 2011-2016 онд нийт 60 иргэн 332.800.000 төгрөгийн зээл авч 94 ажлын байр бий болгосноос 2018 оны байдлаар 237.982.710 төгрөг эргэн төлөгдөж 40 ажлын байр хадгалагдан үлдсэн байна. 2018 онд нийт 63128000 төгрөгийн эргэн төлөлт төлөхөөс 11 дүгээр сарын байдлаар 50.678.343 төгрөг төлөгдөж, эргэн төлөлт 80,2%-тай байна. | 70 |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ** | | | | | | | | |
| **2.1. Хөдөө аж ахуйн чиглэлээр** | | | | | | | | |
| 13 | Хүнсний үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангана. | Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цех байгуулах үүсгэл санаачлагыг бодлогоор дэмжинэ. | Мах, сүү боловсруулах үйлдвэр, цехийн үйл ажиллагааг өргөжүүлсэн байна. | 1-ээс доошгүй | СХС<br>5.0 | 1. Суманд үйл ажиллагаа явуулж буй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, цехийн үйл ажиллагааг тогтворжуулах, ажлын байр нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Суманд шинээр “Оргил” хэрчсэн гурилын цех байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж ажилгүй 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | | Зоорь агуулахыг стандартын шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авч ажиллана. | Мэргэжлийн байгууллагуудтай хамтран зоорь эзэмшигч иргэд, ААНБ-д зоорины стандартын тухай сургалт зохион байгуулах Зоориноос зах зээлд нийлүүлэх мах, төмсний хэмжээг нэмэгдүүлэх Зоорь агуулахад ариутгал хийлгэх ажлыг зохион байгуулах | 1-ээс доошгүй Мах-76,9 тн Төмс, хүнсний ногоо-15,8 тн Хамрагдсан зоорийн тоо -5 | ОНТ | 1. Зоорь, агуулахын тооллого зохион байгуулах<br>2. Зоорь, агуулахыг ариутгал, халдваргүйжүүлэлтэнд хамруулах | Зоорь, агуулахын тооллогын ажлыг зохион байгуулхад суманд төмс, хүнсний ногооны 4, махны 1, ашиглагддаггүй 1 нийт 6 зоорь байна.<br>2. 2018 онд төмс, хүнсний ногооны 4, махны 1 зоорь ашиглалтанд байгаа бөгөөд уг зоориудаас 3 тн мах, 300 кг төмс, хүнсний ногоог зах зээлд нийлүүлж байна. Мөн махны 1 зооринд ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн. | 70 |
| 15 | | Мал нядалгааны цэг байгуулахыг бодлогоор дэмжинэ. | Шаардлагатай дэд бүтцийг шийдвэрлэн, цех байгуулагдсан байна. | 1 | - | 1. Мал нядалгааны стандартын шаардлага хангасан 1 цэгтэй болоход бодлогоор дэмжин ажиллах | 1. 2014 оноос эхлэн 1-р багийн иргэн Б.Батбаяр мах бэлтгэлийн цех ажиллуулж байгаа ба тус цэгийн 1176 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Мал нядалгааны стандартын шаардлага хангасан 1 цэгтэй болох зорилгоор газрын байршлыг эрчимжсэн МАА-н бүсэд гаргахаар газрын асуудлыг шийдвэрлэж зориулалтын бус газар мах нядалгааны цэг ажиллуулж байгаа иргэнийг нүүлгэн шилжүүлэхийг зөвлөөд байна. | 70 |
| 16 | | Хүнсний бүтээгдэхүүний шинжилгээнд тавих хяналтыг сайжруулна. | Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл | 100 хувь | - | 1. Суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад хяналт шалгалтыг улирал бүр зохион байгуулах | Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсэг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлтэй хамтран 20 гаруй хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, борлуулдаг, үйлчилдэг газруудын хүнсний бүтээгдэхүүний шинжилгээнд тавих хяналтыг 4 удаа зохион байгуулж зөвлөгөө өгч гарсан зөрчлийг арилгах үүрэг даалгаварыг өгч ажилласан. | 100 |
| 17 | Бэлчээрийн мал аж ахуйг эрсдлээс хамгаалж, үүлдэр, угсааг сайжруулж, ашиг шимийг дээшлүүлнэ. | Мал үржлийн нэгжийг бий болгон, өндөр ашиг шимт малыг бүртгэлжүүлэх | - Байгуулсан мал үржлийн нэгжийн тоо<br>- Хээлтүүлэгч малыг ангилалт, баталгаажуулалтанд хамруулах | 1<br>100 вь | - | 1. Хувийн мал үржлийн нэгж байгуулах ажлыг зохион байгуулах. | 1. Хувийн мал үржлийн нэгж байгуулах иргэдийг хайж зар тавьсан боловч хүсэлт гаргасан иргэн одоогоор байхгүй болно. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын “Сүмбэр хишигтэн зоо” мал үржлийн нэгжтэй гэрээ байгуулан 2018 оны технологит ажлыг хийж гүйцэтгүүлсэн. Үүнд: Бог малд ангилалт, баталгаажуулалт хийх, ээмэгжүүлэх ажлыг хавар намарын улиралд зохион байгуулж нийт 3000 толгой бог малд ангилалт хийж, 600 малыг ээмэгжүүлсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | | Ямааг ноолуур, махны чиглэлээр, хонь, үхрийг махны чиглэлээр үржүүлж, ашиг шимийг дээшлүүлэх зорилгоор сайн чанарын хээлтүүлэгчээр сайжруулах ажлыг бодлогоор дэмжинэ. | Бог малын хээлтүүлэгч худалдан авч, малчдад гэрээгээр ашиглуулах | 100 хувь | СХС<br>ОНХС<br>2,0 | 1. Суманд бог малын хээлтүүлэгчээр ашиглаж байгаа залаа жинстийн цагаан ухны төлийг 3 малчин өрхөд өгч, ямаан сүргийн үүлдэр угсааг сайжруулах<br>2. Бог малын хээлтүүлэгчийг эх сүргээс нь 100 хувь ялган суурьлуулах ажлыг зохион байгуулах | 1. "Малын үүлдэр угсааг сайжруулах"-аар ОНХС-ийн 2 сая төгрөгийн хөрөнгөөр махны чиглэлийн Керей үүлдэрийн 1 хуц, торгууд үүлдэрийн 1 хуц, керей үүлдэрийн 6 хурган хуц, ноолуурын чиглэлийн 4 ухна худалдан авсан. Сумын 3 малчин өрх залаа жинстийн цагаан ухнаар ямаан сүргийн үүлдэр угсааг сайжруулсан. Мөн нэг өрх Төв аймгийн Баян сумаас Алатау үүлдрийн бухыг авчирч үүлдэр сайжруулагчаар ашиглаж байна.<br>2. Сумын хэмжээнд нийт 243 бог малын хээлтүүлэгчийг эх сүргээс нь ялган суурилуулахаас 113 хээлтүүлэгч буюу 46,5%-тай ялган суурилуулсан. | 100 |
| 19 | | Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор бэлчээрийн худаг засварлах, шинээр гаргах, хортон мэрэгчидтэй тэмцэх, нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулна. | Шинээр гаргах инженерийн хийцтэй худгийн тоо<br>Засварлах худгийн тоо<br><br>Хортон мэрэгчидтэй тэмцэх талбайн хэмжээ.<br><br>Олон наст ургамал тариалах талбайн хэмжээ | 1<br><br>1<br><br>5000 га<br><br>5 га | УТ<br><br>ОНХС<br>1,0 | 1. Бэлчээрийн менежментийн 2018 оны төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулах<br>2. Хавар, намрын бэлчээрийн даац, багтаамжийг тооцох<br>3. Бэлчээрийн хортон мэрэгчийн тандалт судалгааг хийж, тэмцэх шаардлагатай газрын хэмжээ, байршлыг тогтоон хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг зохион байгуулах<br>4. Аймгийн ХХААГ-тай хамтран бэлчээр ашиглах, хамгаалах, олон наст тариалах сургалтанд малчдын төлөөллийг хамруулах<br>5. 1 га талбайд олон наст тариалах ажлыг хашсан талбайтай айл өрхүүдийн дунд өрнүүлэх<br>6. Инженерийн хийцтэй худаг гаргуулах санхүүжилтийг шийдвэрлүүлэх | 1. Бэлчээрийн менежментийн 2018 оны төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай хэрэгжсэн байна.<br>2. Хавар, намрын бэлчээрийн даац, багтаамжийг тооцон ажиллахад хавар ургамлын гарц муу байсан учир бэлчээрийн даац 3 дахин хэтрэлттэй гарч намрын бэлчээрийн даацын мониторинг үнэлгээгээр сумын бэлчээр талхлагдлын байдал дундаж үзүүлэлттэй дунджаар 100 га талбайд 30-40 хонин толгой бэлчээрлэх боломжтой гэсэн үнэлгээтэй гарсан.<br>3. Бэлчээрт тандалт судалгаа хийж сумын нутаг дэвсгэрийн оготно мэрэгч ихтэй газрын байршлыг тогтоож ОНХС-ийн 1 сая төгрөгийн хөрөнгөөр 10 цэгийн 12 га газар, Улсын төсвийн 3,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 цэгийн 2000 га газарт тус тус хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг энгийн, механик, биологийн аргаар зохион байгуулж ажилласан.<br>4. Аймгийн ХХААГ-тай хамтран бэлчээр ашиглах, хамгаалах, олон наст тариалах сургалтанд малчдын 5 төлөөллийг хамруулан ажилласан.<br>5. Олон наст тариалах ажлыг хашсан талбайтай айл өрхүүдийн дунд өрнүүлэн 2-р багийн иргэн Ц.Нэргүй 1 га талбайд олон настын үр цацан ургуулж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 6. Улсын төсвийн 18 сая төгрөгийн хөрөнгөөр сумын 2 дугаар багийн нутаг Тарвагат дулааны энгэр гэдэг газарт бэлчээрийн зориулалтаар шинээр гүний худаг гаргуулан улсын комисс хүлээн авсан. Мөн 22-р зөрлөгийн зүүн талд байрлах бэлчээрийн худаг эвдэрсэнийг малчдын хөрөнгөөр засварлан ашиглаж байна. | |
| 20 | | Малчдыг малжуулах төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Малжуулсан өрхийн тоо<br>Малын тоо | 4<br>240 | - | 1. Ган, зуд гамшгийн эрсдэлд өртсөн, цөөн мал бүхий өрхийг малжуулах<br>2.Малчдыг сургалтанд хамруулж, туршлага судлуулан сайн туршлагыг нэвтрүүлэх | 1. “Иргэдийг малжуулах журам”-ын дагуу цөөн мал бүхий 4 малчин өрхөд тус бүр 40 хонь, 20 ямаа нийт 240 толгой малыг гэрээгээр хүлээлгэн өгч малжуулах ажлыг зохион байгуулсан. Мөн ХХҮГ-аас хэрэгжүүлдэг “Тэгш дүүрэн” хөтөлбөрт Хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 3 өрхийг хамруулж өрх бүрт 32 толгой ямааг хүлээлгэн өгсөн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хүрээнд “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 2-р багийн иргэн Д.Эрдэнэхишигийн төсөл дэмжигдэж гэрээ байгуулан 4 сая төгрөгийн 40 толгой хонийг хүлээн авсан.<br>2. ХААИС-ийн багш нарын зохион байгуулсан бэлчээр ашиглах олон наст ургамал тариалах сургалтанд 5 малчин, Монгол ВИ.И.ТИ.НЕТ ХХК-тэй хамтран зохион байгуулсан малын 10 төрлийн өвчнийг хэрхэн эмчлэх, ямар эмээр эмчлэх тухай сургалтанд 33 малчин, Монголын ХХАА-н хөгжлийн үндэсний нэгдлээс мал, малчинг хөгжүүлэх талаар зохион байгуулсан сургалтанд 18 малчныг тус тус хамруулсан. | 100 |
| 21 | | Сумын өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх | Ажлын гүйцэтгэл | 100 хувь | ОНХС 10,0 | 1.Өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулах | 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 10 сая төгрөгөөр “Өвс тэжээлийн нэгдсэн фондыг нэмэгдүүлэх” ажлыг төлөвлөгөөнд тусгасны дагуу иргэн Б.Баяртогтох, Т.Батнасан нартай гэрээ байгуулан 1512 боодол өвс худалдан авч өвсний фондыг нэмэгдүүлсэн. | 100 |
| 22 | Эрчимжсэн аж ахуйг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | Гахай, тахианы аж ахуй эрхлэгчдийг эрчимжсэн аж ахуйн бүсэд төвлөрүүлнэ. | Эрчимжсэн аж ахуйн бүсэд газар олгогдсон иргэн, аж ахуй нэгжийг шилжүүлэх тоо | 2-оос дээш | - | 1.Гахай, тахианы аж ахуй эрхлэгчдийн судалгааг гаргах<br>2.Газар олгох ажлыг зохион байгуулах | Сумын хэмжээнд гахайн аж ахуй эрхлэгч-3 иргэн, тахиан аж ахуй эрхлэгч-2 иргэн байна. Эрчимжсэн мал аж ахуйн бүс нутагт гахай, шувууны аж ахуй эрхлэдэг 5 өрхөд нийт 1,25 га газрыг эзэмшүүлэн олгосны дагуу гахайн аж ахуй эрхлэдэг -2 иргэн нүүж гахайн байраа барьж төвлөрөөд байна. | 70 |
| 23 | Мал эмнэлгийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, | Мал, амьтны ужиг халдварт өвчнөөс урьдчилан | Ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга | 100 хувь | - | 1. Эпизоотлогийн дагуу технологит хугацаанд нь чанартай хийлгэх | 1. Сумын “ДЭОР” ХХК-тай гэрээ байгуулан мал, амьтны ужиг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн дагуу хийлгэж гоц халдварт болон халдварт | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | малын халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлнэ. | сэргийлэх арга хэмжээг технологийн дагуу хэрэгжүүлнэ. | хэмжээнд хамруулах мал | | | 2. 2019 оны мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, ажил үйлчилгээний хөлсийг ИТХТ-ийн хурлаар батлуулах | өвчнөөс урьдчилан сэргийлэх 13 нэр төрлийн вакциныг 171940 толгой мал, амьтанд хийж гүйцэтгэсэн.<br><br>2. 2019 оны мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын тоо, ажил үйлчилгээний хөлсийг ИТХТ-ийн 2018 оны 13 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 |
| 24 | Газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | Усалгаатай газар тариаланг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн хангамжийн хувь, нэгж га-аас авах ургацыг нэмэгдүүлнэ. | Эргэлтийн талбайн хэмжээ<br>Талбайн ашиглалт<br>Нэгж ургацын хэмжээ | 9,7 га<br>70 хувь<br>65 н/га | - | 1. Аймгийн ХХААГ-тай хамтран газар тариалангийн технологийн сургалт зохион байгуулах<br>2. Төмс – 3,5 га, хүнсний ногоо – 6,5 га, тэжээлийн ургамал – 1 га, жимс, жимсгэнэ – 0,2 га талбайд тариалж, төмс 70 цн/га, хүнсний ногоо 70 цн/га, тэжээлийн ургамал 28,3 цн/га нэгжийн ургац авах<br>3. Сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдийн хүнсний хэрэгцээнд хүнсний ногооны 50%, мах, сүүг 100% нийлүүлсэн байх<br>4. “Ургац 2018” болзолт удалдааныг сурталчилж, сумын тариалан эрхлэгч иргэн, албан байгууллагыг хамруулах | 1. Аймгийн ХХААГ-тай хамтран газар тариалангийн технологийн сургалтыг нийт 16 иргэнд зохион байгуулж, арга зүйн заавар зөвлөмжийг өгч ажилласан. Мөн ХААИС-ийн багш нарын зохион байгуулсан олон наст ургамал тариалах сургалтанд 5 иргэнийг хамруулсан.<br><br>2. Сумын 3 иргэн төмс 3,8 га талбайд тариалж 29,4 тн ургац, хүнсний ногоо 3 га талбайд тариалж 64,237 тн ургац хураан авч иргэдийн хүнсний ногооны хэрэгцээнд нийлүүлээд байна. “Жимс жимсгэнэ” дэд хөтөлбөрийн хүрээнд 2 албан байгууллага, 2 ахмад настан, 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхөд 60 чацаргана, 40 үхрийн нүд жимсний суулгацыг үнэ төлбөргүй олгож суулгуулсан.<br><br>3. Сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдийн хүнсний хэрэгцээнд хүнсний ногооны 50%, мах, сүүг 100% нийлүүлэх гэрээний дагуу 1 хоршоо 7 өрх мах, сүү, ногоог нийлүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна.<br><br>4. Аймагт зохин байгуулагдах “Ургац 2018” болзолт уралдаанд сумын 2 иргэнийг хамруулахаар материалыг нь хүргүүлээд байна. | 100 |
| 25 | | Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, ургацыг нэмэгдүүлнэ. | Шинээр ашиглалтанд оруулах хүлэмжийн хэмжээ | 120 $м^2$ | СХС – 5,0 | 1. Аймгийн ХХААГ-тай хамтран хүлэмжийн ариутгал, халдваргүйжүүлэлт болон өвөл, зуны хүлэмж байгуулах тухай сургалт зохион байгуулах<br><br>2. Хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжих | 1. Аймгийн ХХААГ-тай хамтран хүлэмжинд ногоо тариалах, хүнсний ногоог хэрхэн арчлах сэдэвт сургалтанд газар тариалан эрхэлдэг 5 иргэнийг хамруулсан. Мөн Улаанбаатар хот, Дорнод аймаг, Өмнөговь аймгуудад зохион байгуулагдсан хүлэмжийн ариутгал, халдваргүйжүүлэлт болон өвөл, зуны хүлэмж байгуулах тухай сургалтанд хүлэмжийн аж ахуй эрхэлдэг 4 иргэнийг хамруулсан.<br><br>2. Хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлэхээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнийг хамруулан 120$м^2$ - тай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүлэмжинд хүнсний ногоо тариалж 0,5 тн ургац хураан авсан. | |
| 26 | | Чацаргана болон бусад жимс, жимсгэнэ тариалахыг дэмжинэ. | Шинээр тариалах талбайн хэмжээ | 0.5 га | - | 1. Жимс, жимсгэнэ тариалах сургалтанд иргэдийг хамруулах<br>2. Шинээр 0.5 га талбайд чацаргана болон бусад жимс, жимсгэнэ тариалах<br>3. "Жимс жимсгэнэ" дэд хөтөлбөрийг эрчимжүүлэх | 1. Аймгийн ХХААГ-тай хамтран жимс жимсгэний модыг хэрхэн суулгах, арчлах талаарх сургалтанд 5 иргэнийг хамруулж, жимсний мод олгосон 2 байгууллага, 6 иргэнд жимсний мод тарих заавар зөвлөгөө өгсөн.<br>2. "Жимс жимсгэнэ" дэд хөтөлбөрийн хүрээнд 2 албан байгууллага, 2 ахмад настан, 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй өрхөд 60 чацаргана, 40 үхрийн нүд жимсний суулгацыг үнэ төлбөргүй олгож 0,032 га-д суулгуулсан. Өмнө жилүүдэд тариалсан 0.05га талбайн чацарганы суулгац жимсэлж 6 кг чацаргана хураан авсан. | 100 |
| 27 | Хөнгөн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ. | Цагаан сар, Намрын ногоон өдрүүд үзэсгэлэн худалдаа, Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн зохион байгуулна. | Зохион байгуулах арга хэмжээний тоо | 2, 9-р сард тус бүр 1 удаа зохион байгуулна. | - | 1. Нэг суурин Нэг бүтээгдэхүүн үзэсгэлэн худалдаа зохион байгуулна<br>2.Аймгийн үзэсгэлэн худалдаанд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг хамруулах<br>3. Сав баглаа боодлын өнгө үзэмжийг сайжруулах тал дээр зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх | 1. ЖДҮ эрхлэгч иргэдийн үйл ажиллагааг дэмжиж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчилах, борлуулах зорилгоор "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" үзэсгэлэн худалдааг 2018 оны 09-р сард зохион байгуулж 13 иргэн 6 нэр төрлийн бараа, бүтээгдэхүүнээр оролцож төрөл тус бүрийн ялагчийг тодруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.<br>2. Аймгийн үзэсгэлэн худалдаанд 4 иргэн 3 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр амжилттай оролцсон.<br>3. Суманд шинээр байгуулагдсан хэрчсэн гурилын цех болон цэвэр усны үйлдвэрийн үйл ажиллагаа, савлалтанд хяналт тавьж зөвлөн туслах үйлчилгээг 2 удаа үзүүлж ажилласнаар уг хоёр үйлдвэр хаяг болон савлагаандаа өөрчлөлт хийж сайжруулсан. | 100 |
| **Газрын харилцаа, барилга хот байгуулалт, дэд бүтцийн чиглэлээр** | | | | | | | | |
| 28 | Газар зохион байгуулалтын менежментийг сайжруулж, газар олголтыг эрчимжүүлнэ. | Иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ. | Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө | 100 в ь | - | 1. Иргэдээс газар өмчлөлийн өргөдөл хүлээн авч, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу газрыг иргэдэд бүрэн өмчлүүлэх<br>2. Газар өмчлөлийн дэлгэрэнгүй судалгааг гаргах | 1. Сумын 2018 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2 байршилд 26.5 га газрыг 250 иргэнд сумын Засаг даргын 2018 оны А/56 дугаар захирамжаар өмчлүүлэн улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж байна.<br>2. 2018 оны жилийн эцсийн байдлаар 2027 иргэн буюу сумын нийт хүн амын 58 % нь "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай" хуулийн дагуу 1 удаа үнэ төлбөргүй газраа өмчилж авсан байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  | |
| 29 | | Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг батлуулж, газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийг нээлттэй зохион байгуулах | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 100 хувь | - | 1. 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах<br>2 Аймгийн ГХБХБГазар, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран нээлттэй хаалганы өдөрлөгийг улирал дутам зохион байгуулах | 1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07 дугаар тогтоолоор сумын 2018 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж мөрдөн ажиллаж байна.<br>2. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран суманд 2018 онд "Нээлттэй хаалганы өдөрлөг"-ийг 2 удаа зохион байгуулж 100 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлж зөвлөгөө өгч, 78 гарын авлага, тараах материал тарааж, 11 иргэний өмчлөлийн газарт хэмжилт хийн, 72 иргэн газар өмчилсөн материалаа сумын газрын даамалаас авч, Улсын бүртгэлд бүртгэх ажлыг тус тус зохион байгуулж ажилласан. | 100 |
| 30 | | Сумын төвийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах | Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл | 100 хувь | ОНХС 5.0 | 1. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хаягжуулалтын зургийг батлуулах<br>2. Сумын төвийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах ажлыг зохион байгуулах | 1. Суманд хаягжуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг хаягжуулалтын бичиг баримтыг боловсруулан зураг төсвийг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулж, сумын төв гудамжийг "Уурхайчдын өргөн чөлөө" хэмээн нэрлэсэн.<br>2. Сумын төвийн гудамж талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах ажлыг 2018 оны ОНХС-ийн 4,8 сая төгрөгийн хөрөнгөөр "Их эффект" ХХК-тай гэрээ байгуулан сумын төвийн орон сууцны 22 хаяг, орцны 53 хаяг, Обеъктын байрлал заасан 1 хаяг, байшин барилгын-33 хаяг нийт 108 ширхэг хаягийг хийж байршуулсан. | 100 |
| 31 | | Газрын биржийн цахим системийг нэвтрүүлж, иргэдэд үйлчилж эхлэнэ. | Төлөвлөсөн ажлын гүйцэтгэл | 100 хувь | - | 1. Газрын харилцааны мэдээллийг цахим системд тавьж ил тод хүргэх | 1. Газрын цахим биржийг нэвтрүүлэн газартай холбоотой мэдээ мэдээллийг олон нийтэд ил тод болгох зорилгоор 2018 онд эзэмшүүлэх, барьцаалах, төсөл сонгон шалгаруулалтын зар, газрын зах зээлийн үнийн мэдээ зэргийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байршуулан ажилласан. Үүнд:<br>➢ Газар эзэмших эрхийн барьцаалбар - 68<br>➢ Газрын зах зээлийн үнийн 21 мэдээ -21<br>➢ Төсөл сонгон шалгаруулалтын зар – 1-ийг тус тус газрын биржид бүртгэн ажилласан байна. Зураг | 70 |
| 32 | | Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлаж, гэрчилгээг шинэчилж, солих ажлыг эхлүүлнэ. | Тухайн жилийн гүйцэтгэл | 100 хувь | - | 1. Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах<br>2. Газрын кадастрын гэрчилгээг шинэчилж солих ажлыг зохион байгуулах | 1. Газрын кадастрын мэдээллийн санг солбилцлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэн “Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбилцол өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх” ажлын хүрээнд ЛМ-2 программ хангамжийг нэвтрүүлэн 2018 онд олгосон 250 иргэний материалыг бүртгэн ажиллаж байна. 2018 онд газрын кадастрын мэдээллийн сангийн 89 иргэний өгөгдлийг засварласан.<br>2. Иргэн аж ахуй нэгж байгууллагын хувийн хэргийн нөхөн бүрдүүлэлтийн ажлыг зохион байгуулж зөрлөг хороололд газар олгосон 83-Иргэн, 6-ААНБ-ын материалыг засварлан шинэчилсэн. Мөн Аймгийн ГХБХБГ-т нэгж талбарын хувийн хэргийн бүрдэлийг ханган хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна. | 70 |
| 33 | Хот суурин газрын дэд бүтцийг нэмэгдүүлж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэн, хот тохижилтыг сайжруулна. | Суманд цэвэрлэх байгууламж байгуулах зураг төсвийг боловсруулна. | Зураг төсөв боловсруулах ажлын явц | Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна. | ОНХС | 1. Орон нутгийн хөгжлийн сангийн 16 сая төгрөгөөр зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг зохион байгуулах | Аймгийн Засаг даргын 2018 оны А/125 дугаар “Ажлын хэсэг томилох тухай” захирамжаар суманд бага оврын цэвэрлэх байгууламж байгуулах ажлын судалгааг хийх, зургийн даалгавар боловсруулах ажлын хэсэг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж уг ажлын зураг төсвийг боловсруулах тооцоолол хийсэн боловч судалгаагаар зураг төсвийн зардал өндөр гарсан тул 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийлгэхээр саналыг тусгаад байна. | 40 |
| 34 | | Зүүн гэр хорооллын ундны усны худгийг цахимжуулж, байрыг засварлах | Ажлын гүйцэтгэл | 100 хувь | ОНХС 10,0 | 1. Зүүн гэр хорооллын ундны усны худгийг цахимжуулах, худгийн байрыг засварлах | Сумын 2018 оны ОНХС-ийн 10 сая төгрөгийн хөрөнгөөр Зүүн гэр хорооллын ундны усны худгийг цахимжуулах, худгийн байрыг засварлах ажлын гүйцэтгэгчээр “Сүмбэр зууч” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн. 2018 оны жилийн эцсийн байдлаар үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 35 | Орон нутгийн чанартай авто замын сүлжээг өргөтгөж, засварлана. | Сумыг босоо тэнхэлгийн авто замтай холбох ажлын зураг төсвийг боловсруулах | Ажлын явц | Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна. | ОНХС | 1.Зураг төсөв боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний тендерийг зохион байгуулах | Сумын төвөөс босоо тэнхэлгийн авто зам хүртлэх засмал замын ажлын зураг төсвийг 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийлгэхээр иргэдийн саналыг авч нэгдсэн жагсаалтад эрэмбэлээд байна. | Үнэлэх болом жгүй |
| 36 | | Сумын төв доторх засмал зам тавих зураг төсвийг боловсруулах | Ажлын явц | Зураг төсвийг бүрэн хийлгэж, хүлээн авсан байна. | ОНХС | 1.Зураг төсөв боловсруулах ажлын зөвлөх үйлчилгээний тендерийг зохион байгуулах | Сумын төв доторх засмал зам, явган хүний замын ажлын зураг төсвийг 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийлгэхээр иргэдийн саналыг авч нэгдсэн жагсаалтад эрэмбэлээд байна. | Үнэлэх болом жгүй |
| 37 | | Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэгүүдэд урсгал засвар хийх. | Засвар хийгдэх гэрэлтүүлгийн тоо | 3 гэрэлт цамхаг 37 гэрэлтүүлэг | ОНХС 5,7 | 1. Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засварын ажлыг зохион байгуулах. | “Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар үйлчилгээ хийх”- ажлыг “Энхжих фармат” ХХК-тай гэрээ байгуулан 5,74 сая төгрөгийн хөрөнгөөр 6,7-р байрны нарны зайн гэрлийн 7 акумлятор, 4 гэрлийн цамхагын 24ш гэрэл, зүүн гэр хорооллын гудамжны 18 гэрлийг тус тус сольсон. | 100 |
| **ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **3.1. Эрүүл мэндийн чиглэлээр** | | | | | | | | |
| 38 | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Эрүүл мэндийн төвийг шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангана. | Хүүхдийн түргэн тусламжийн багаж хэрэгсэл | 100 хувь | БТ, ОНХС | 1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр сумын Эрүүл мэндийн төвд 4D эхо томографик аппарат худалдан авах | 1. Орон нутгийн хөгжлийн сангийн 50 сая төгрөгийн хөрөнгөөр эрүүл мэндийн төвд “ЭХО томографик 4D аппарат худалдан авсан. Мөн Эрүүл мэндийн төвийн хөрөнгөөр сахарын 3ш аппаратыг 135000 төгрөгөөр худалдан авч, 2018 оны 11 сарын байдлаар эрсдэл бүхий 760 иргэн хамрагдахаас 92.5% буюу 703 иргэний сахарыг тодорхойлсон байна. | 100 |
| 39 | | Эрүүл мэндийн төвийн нөхөн үржихүйн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног, төхөөрөмж, багаж хэрэгслээр хангана. | Эх, нярайн анхны тусламжийн багаж хэрэгсэл Нялхсын эндэгдлийн түвшин | 100 хувь Эндэгдлийн түвшин буурсан байна. | БТ | 1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр нярайн иж бүрдэл, мазок шинжилгээний оношлуураар хангах<br>2. Эх нярайд хяналт тавьж ажиллаж нялхсын эндэгдэл гаргахгүй байх | 1. Сумын Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийн төвд нярайн 5 ширхэг иж бүрдэл, 100 удаагийн мазок шинжилгээний иж бүрдлийг 300000 төгрөгөөр худалдан авч зорилтот бүлгийн 100 эмэгтэйг шинжилгээнд хамруулсан. Мөн сумын иргэдийн хандиваар Эрүүл мэндийн төвд 660.000 төгрөгийн үнэтэй хүүхдийн судас тодосгогч аппарат, ШОХК-ийн 15 сая төгрөгийн хандиваар хүүхдийн тусламж үйлчилгээний 12 нэр төрлийн багц хэрэгслийг олгосон.<br>2. Сумын эрүүл мэндийн төв нь эх нярайн хяналтыг сайжруулахын тулд төрсний дараах хяналтын үзлэгийг шинээр төрсөн эх, нярайд 7 хоног бүр хийж, товлолт вакцинжуулалтанд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамруулж ажилласнаар нялхсын эндэгдэл гараагүй болно. 2018 оны 11 сарын байдлаар нийт 74 эх хяналтанд байгаа бөгөөд шинээр 39 эмэгтэйг жирэмсний эрт хяналтанд авч, давхардсан тоогоор 316 удаа үзлэгт хамруулсан байна. Мөн шинээр төрсөн 55 эхэд 416 удаагийн гэрийн эргэлт хийж ажилласан. Мөн эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 6 сэдвийн хүрээнд нийт 136 эмэгтэйд зохион байгуулсан. | |
| 40 | | Зонхилон тохиолдох В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтыг бууруулахад шаардлагатай оношлуур тоног төхөөрөмжөөр хангана. | Эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтын хувь | 25-аас дээш хувиар нэмэгдсэн байна. | ОНХС | 1. “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн II үе шатыг суманд хэрэгжүүлэх.<br>2. Сүрьеэ өвчний эрт илрүүлгийн шинжилгээ оношилгооны ажлыг зохион байгуулах<br>3. “Цус эрүүл бол бие эрүүл” аян зохион байгуулах<br>4. Хорт хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулах. | 1. Монгол улсын Засгийн газрын тогтоолоор “Элэг бүтэн Монгол-2” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сумын хэмжээнд 15-39 насны 1461 иргэн хамрагдахаас 861 иргэн буюу 60%-ийг шинжилгээнд хамруулж, зорилтот бүлгийн 827 иргэнд гарын авлага тарааж эрүүл мэндийн боловсрол олгосон. Элэгний В вирустай 45, С вирустай 21, нийт 66 иргэнийг аймгийн нэгдсэн эмнэлгийн халдвартын эмчийн хяналтанд илгээсэн.<br>2. Сумын “Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд Сэлэнгэ аймгийн диспансерийн хяналт, аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран сүрьеэ өвчний эрт илрүүлгийн шинжилгээ оношилгоог 450000 төгрөгийн төсөвтэйгээр 10 дугаар сард зохион байгуулж, сумын 416 иргэнийг рентген шинжилгээнд, уушигны эмгэг, сэжиг бүхий 45 иргэнийг цэрний шинжилгээнд тус тус хамруулж, сорьцыг ХӨСҮТ-д хүргүүлээд байна.<br>3. Аймгийн Засаг даргын захирамжаар зарлагдсан “Цус эрүүл бол бие эрүүл” аяны хүрээнд 2018 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1872 иргэн хамрагдахаас 1010 иргэн буюу 54%-ийг хамруулж, шинжилгээний дээжийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт хүргүүлээд байна. Графикаар харьцуулбал:<br><br>"Цус эрүүл бол бие эрүүл" аяны хамрагдалт<br>1480<br>1010<br>2017 он<br>2018 оны 10 сарын 30-ны байдлаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | | | | | | | 4. 2018 оны 10 сарын 30-ны өдрийн байдлаар хөхний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт 1006 эмэгтэй хамрагдахаас 799 эмэгтэй буюу 79.4%, умайн хүзүүний эсийн шинжилгээнд 125 иргэн хамрагдахаас 104 эмэгтэй буюу 83%-ийн хамрагдалттай байна. Хамрагдаагүй шалтгааныг тодруулбал умайн хүзүүний эсийн шинжилгээнд хамрагдах товлолт хугацаа болоогүй 21 иргэн, хөхний хавдраас урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй иргэдийн дийлэнх хувийг суманд харьяалалтай боловч өөр орон нутагт түр оршин сууж буй иргэд эзэлж байна. | |
| 41 | | Настны эрүүл мэндийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээг зохион байгуулна. | Үзлэгт хамрагдалтын хувь | 60 –аас дээш байна | БТ | 1.Геронтологийн үндэсний төвийн эмч нартай хамтран нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, шинжилгээг зохион байгуулах | “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Геронтологийн төвтэй хамтран 2018 оны 10 сард сумын 38 ахмад настан болон байнгын асаргааны 3 ахмад настанг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулсан. Мөн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний “Өдрийн үйлчилгээ”-ний үеэр сумын 50 ахмад настанг эмчийн үзлэгт хамруулж бариа засал хийлгэсэн. “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд байнгын асаргаа шаардлагатай 27 иргэнийг жилд 2 удаа витаминжуулалтанд хамруулж нийт 300000 төгрөгийн витаминжуулалтын ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 42 | | Эрүүл мэндийн төвд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд иргэдэд сургалт, сурталчилгааны ажлуудыг чанартай, үр дүнтэй, шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулж, гарын авлага шинээр хийж сургалт, сурталчилгаанд ашиглах | - Сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулагдсан байна.<br>- Сургалтанд хэрэглэгдэх гарын авлага бэлтгэсэн байна | Сар бүр<br><br>10-аас дээш төрөл | УТ | 1. Эрүүл мэндийн төвд хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтуудыг зохион байгуулах | 1. 2018 онд Нийгмийн эрүүл мэндийн 13 үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж, Засгийн газрын 224 дүгээр тогтоолын дагуу хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаа 1, Аян 2, тэмдэглэлт өдөр 4-ийг зохион байгуулан ажилласан. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 17 сэдвээр, 17 төрлийн гарын авлагыг тараан давхардсан тоогоор 1378 иргэнд зохион байгуулж, нүүр номын хуудсаар 15 төрлийн зурагт хуудас, Эрүүл мэндийн төвийн амбулаторийн хэсгийн телевизээр 9 төрлийн видео шторкыг явуулж иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох ажлыг хийсэн. | 100 |
| **3.2. Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр** | | | | | | | | |
| 43 | Цэцэрлэг, сургуулийн хүрэлцээ хангамжийг | СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх, хувилбарт | Хамран сургах тойргийн бүх хүүхдийг хамруулсан | 100 хувь | БТ | 1. 2-5 насны хүүхдийн судалгаанд үндэслэн СӨБ-д бүрэн хамрагдах нөхцөл боломцоог хангах санал боловсруулж, хэрэгжүүлэх | 2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 394 хүүхдээс 384 хүүхэд /3-р цэцэрлэгт 347, Бүжинхэн бүл цэцэрлэгт 29, хүүхэд харах үйлчилгээнд 8/ хамрагдаж хамран | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэмэгдүүлж, боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулна. | сургалтыг зохион байгуулах | байна. | | | | сургалт 97 хувьтай байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 382 хүүхдээс 3-р цэцэрлэгт 344 хүүхэд, 21-р зөрлөгийн салбар бүлэгт 11 хүүхэд, Бужинхэн бүл цэцэрлэгт 25 хүүхэд тус тус хамрагдаж хамран сургалт 99.4 хувьтай байна. .<br>2017-2018 оны хичээлийн жилд 3-р цэцэрлэгт суралцаж буй 347 хүүхэд, 3-р сургуульд суралцаж буй 689 хүүхдийн мэдээлэл, 2018-2019 оны хичээлийн жилд 3-р цэцэрлэгт суралцаж буй 344 хүүхэд, Ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй 694 хүүхдийн мэдээллийг тус тус мэдээллийн нэгдсэн санд 100% бүртгэсэн. | |
| 44 | | Цэцэрлэгийн сургалтын орчин, тоглоом наадгайн хангамжийг нэмэгдүүлэх | Сургалтын таатай орчин бүрдсэн байна. | Хүүхэд нэг бүрийн хөгжих боломжоор хангагдсан байна. | БТ | 1. Цэцэрлэгийн сургалтын орчинг тохижуулж, сургалтын шинэлэг арга зүйг нэвтрүүлэх | 2018 оны ОНХС-ийн хөрөнгөөр гэр цэцэрлэгт 1 гэр, 30 ш гудас, хөнжил болон 60 хос цагаан хэрэглэлийг “Оч хийц” ХХК-тай гэрээ байгуулж, 6027100 төгрөгөөр худалдан авсан.<br>Цэцэрлэгийн эцэг эхчүүдийн дунд бооцоот гар бөмбөгийн тэмцээн зохион байгуулж эхний 3 байрт шалгарсан 3 бүлэгт 500000 төгрөгийн тоглоом бэлэглэж 3 бүлгийн тоглоомын тоог нэмэгдүүлсэн.<br>Байгууллагын зардлаар 74 хос даавуу, багшийн ширээг худалдан авч нийт 1.2 сая төгрөгийг зарцуулж, 2018-2019 оны хичээлийн жилийн бүртгэлийн хураамж 320000 төгрөгөөр бага бүлгийн багшийн 2 ширээ, дунд бүлгийн тоглоомын тавиурыг худалдан авч тохижуулсан.<br>Эцэг эхийн санаачилгаар бага бүлгүүдэд 2.1 сая төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомын хангамжийг нэмэгдүүлсэн. | 100 |
| 45 | | Цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоол, “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэд эцэг, эх, олон нийтийн хяналтыг тогтмолжуулах. | - Хяналт тавьсан тоо<br>- Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам | - 8 удаа<br>- 100 хувь | БТ | 1.Цэцэрлэгийн хүүхдийн хоолны хөндлөнгийн шалгалтыг зохион байгуулах<br>2. “Үдийн цай” хөтөлбөрт эцэг эх, багш, сургалтын менежер, сургуулийн эмч хяналт тавих | 1. 3-р цэцэрлэгийн дотоод хяналтын үнэлгээг улирал тутам хийж хэвшсэн. Мөн ЗДТГ-ын зүгээс хоолны дээж хадгалалт болон хоолны орц нормын талаар 14 хоног тутамд танилцаж байна. Цэцэрлэгийн хоолны орц норм, амт чанарт гарсан зөрчилгүй байна. Эцэг эхийн хоол амталгааны үйл ажиллагааг тогтмолжуулж, бүлэг болгон сар бүр 5, 5 эцэг эхийн хяналтыг хийлгэж хэвшсэн.<br>2. 2017-2018 оны хичээлийн жилд сургуулийн “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээг “Сүмбэр Шүтээн” ХХК-тай байгуулан 400 сурагчийг хамруулан ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн Хяналтын комисс хөтөлбөрийн үйл ажиллагаанд улирал бүр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хяналт тавьж, гэрээний хэрэгжилтийг үнэлэн ажилласан. Эцэг эхийн хөндлөнгийн хяналтыг өдөр тутмын амталгаагаар зохион байгуулж хэвшээд байна. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь сурагчдаас “Дур сонирхлын судалгаа”-г авч хоолны нэр төрөлд баяжилт хийсэн. ЗДТГ-ын зүгээс 4 удаа “Үдийн цай”-г хэрэгжүүлэх, мөрдөх журмын үзүүлэлтүүдийн дагуу хяналт тавьж, хоолны цэсийг сургуулийн эмч боловсруулж байх зөвлөмжийг өгч ажилласан. 2018-2019 оны хичээлийн жилийн эхний улиралд “Сүмбэр Шүтээн” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг комиссын 7 хүний бүрэлдэхүүнтэй хийж, 89%-тай дүгнэгдэж, гэрээг сунган ажиллаж байна. Мөн эрүүл мэндийн үзлэгт сургууль, цэцэрлэгийн 30 багш, 7 тогооч, 1 эмч, 2 нярав нар хугацаандаа бүрэн хамрагдсан. | |
| 46 | | Төгсөгчдын ЭЕШ-ын дундаж оноо өмнөх оны дунджаас өссөн байх | - Өмнөх оны дунджаас өссөн байна | - 0-5 оноо | - | 1.Элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | 2017-2018 оны хичээлийн жилд 36 сурагч төгсөхөөс 34 сурагч ЭЕШ өгөхөөр бүртгүүлснийг графикаар харуулбал:<br><br><br>ЭЕШ-ын аймгийн чиглүүлэгч багш, судлагдахуун бүрийн багш нарын давтлагын чанар, сар бүр сорилго авч ажилласны үр дүнд сумын Ерөнхий боловсролын сургууль нь ЭЕШ-ын 8 судлагдахууны дундаж оноогоор улсын дунджаас дээгүүр шалгагдаж аймагтаа тэргүүн байр эзэлсэн. Судлагдахуун бүрийн дундажийг улсын дундажтай харьцуулбал: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |  | |
| 47 | | 3-р сургуулийн цахилгааны шугамыг хэсэгчлэн шинэчлэх | Ажлын гүйцэтгэл | 100 хувь | ОНХС 20,0 | 1.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3-р сургуулийн цахилгааны шугамыг хэсэгчилэн шинэчлэх ажлыг гүйцэтгүүлэх | 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 19.7 сая төгрөгийн хөрөнгөөр 3 дугаар Сургуулийн цахилгааны монтажыг хэсэгчилэн шинэчлэх ажлыг “Энхжих формат” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, улсын комисс хүлээн авсан. | 100 |
| 48 | | Хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн хүүхдүүдийг хичээлийн хэрэгслэлээр хангах ажлын санаачлан дэмжих | - Хичээлийн хэрэгслэлээр хангагдсан хүүхдийн тоо | - 30-аас доошгүй | ОНХС | 1.Сумын дэд хөтөлбөрүүдийн санхүүжилтээр бүтэн, хагас өнчин, нэн ядуу өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хичээлийн хэрэгслийг бэлтгэж гардуулах<br>2.Хичээлийн шинэ жилийг тохиолдуулан иргэд, байгууллага аж ахуйн санаачилгаар зохион байгуулах дэмжлэг туслалцааны ажилд хамтран ажиллаж, мэдээлэл, судалгаагаар хангах | 1. Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд хичээлийн шинэ жилийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй болон эмзэг бүлгийн 32 хүүхдэд 700000 төгрөгийн хичээлийн хэрэгсэл бэлтгэн гардуулсан.<br>2. “Шивээ-Овоо” ХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд хичээлийн шинэ жилийг тохиолдуулан сумын амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 26 өрхийн 26 хүүхдэд 3.5 сая төгрөгийн сурагчийн дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл гардуулсан. | 100 |
| 49 | Соёл, урлагийн байгууллагууд ын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ. | Сумын номын сангийн номын фондыг нэмэгдүүлж орон нутаг судлах танхимыг тохижуулах | Нэмэгдүүлсэн номны тоо | 50-аас доошгүй | ОНХС 3,0 | 1.Номын сангийн фондыг нэмэгдүүлэх<br>2.Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Орон нутаг судлах танхимын үзмэрийг баяжуулах | 1. БСШУСЯ-ны 1 сая төгрөгийн хөрөнгөөр 70 нэр төрлийн номыг худалдан авч сумын номын сангийн фондыг нэмэгдүүлсэн. Мөн аймгийн Музейн хандиваар 27 хуучин ном хүлээн авч, баяжилт хийсэн.<br>2. “Нийтийн номын сангийн фонд болон орон нутаг судлах танхимыг тохижуулах”- ажлын хүрээнд сумын Засаг даргын А/38 Захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг худалдан авалтыг зохион байгуулж 1.5 сая төгрөгөөр 8 төрлийн үзмэр /амьтны чихмэл/ худалдан авсан. Үүнд: Чоно, Үнэг, Дорго, Унага, Зурам, Өмхий хүрэн, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ятуу шувуу, Турлиах хэрээ тус тус худалдан авсан. Мөн орон нутаг судлах танхимд цонх гаргаж вакум цонх хийсэн. | |
| 50 | | Боржигин морин хуур, уртын дууны сургалтыг зохион байгуулах | Хамрагдсан хүүхдийн тоо | 20-оос доошгүй | ОНХС | 1.Боржигон морин хуурын сургалтанд шинээр 20 сурагч хамруулах<br>2. Боржигон уртын дууг ирэдэд сурталчилах ажлыг зохион байгуулах | 1. 2017-2018 оны хичээлийн жилд Боржигон морин хуураар сургуулийн 20 сурагч хичээллэж, сумын 1-р багийн иргэн уртын дууч О.Алтанхүү ЕБС-ийн 10 сурагчид Боржигон уртын дууг зааж сургаснаар аймагт зохион байгуулагдсан “Боржигон морин хуур”-ын уралдаанд ЕБСургуулийн 11-р ангийн сурагч н.Наранмандах тэргүүн байр эзэлсэн.<br>2. Хүүхэд, багачуудад Боржигон өвийг сурталчилж, сургах зорилгоор жил бүрийн сурагчдын урлагийн үзлэгийн төрөлд Боржигон морин хуур, уртын дууны төрлийг оруулж, хүүхэд залуучууд төдийгүй эцэг эхчүүдэд сурталчилж ажилласан. Мөн сумын баяр наадмаар Боржигон морин хуур, уртын дууг сурталчилан мэндчилгээ дэвшүүлсэн. | 100 |
| 51 | | Хөдөөгийн багийн иргэдэд үзүүлэх соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх | - Зохион байгуулах соёл, урлагийн арга хэмжээний тоо<br>- Хамрагдах иргэдийн тоо | - 3-аас доошгүй<br>- Хөдөөгийн иргэдийн хүн амын 30 хувиас доошгүй | - | 1.“Малчдын нэг өдөр” өдөрлөг зохион байгуулах<br>2.Хөдөөгийн иргэдэд соёлын явуулын үйлчилгээг үзүүлэх /2 удаа/ | 1. Аймгийн Боржигин чуулгатай хамтран 2018 оны 05 сард малчдад Соёлын явуулын үйлчилгээг үзүүлж, 30 гаруй малчин өрхийг хамруулсан.<br>2. “Малчдын нэг өдөр” өдөрлөгийг 2018 оны 09 сард 2-р багийн малчдын дунд зохион байгуулж иргэдийн санал бодлыг сонсож, тулгамдсан асуудлыг газар дээр нь шийдвэрлэж ажилласан. Мөн явуулын номын сангаар үйлчилж, азын сугалаа сугалуулах, хөл бөмбөг, хөгжөөнт буухиа, АХА зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. | 100 |
| 52 | | Өрх бүрт угийн бичгийг хөтлүүлж хэвшүүлэх талаар холбогдох ажлыг зохион байгуулах | - Угийн бичиг хөтлөх талаар зохион байгуулах сургалтын тоо<br>- Хамрагдах өрхийн тоо | - 2<br>- сумын нийт өрхийн 50-аас доошгүй хувь | Хөтөлбөр | 1. “Угийн бичиг хөтлөх арга зүй” сургалт зохион байгуулж, сургалтын материал, гарын авлага бэлтгэж, тараах<br>2. Угийн бичиг хэн сайн хөтлөх вэ? Уралдаан зарлах | 1. Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд 184000 төгрөгийн төсөвтэйгээр угийн бичгийн сургалтыг зохион байгуулж 6 байгууллагын 105 албан хаагчдыг буюу сумын нийт өрхийн 10%-ийг хамруулсан.<br>2. Сургалтанд хамрагдсан иргэдийн дунд “Хэн сайн угийн бичгээ хөтлөх вэ” уралдааныг зарлаад байна. Уралдааныг 12 сард дүгнэнэ. | 70 |
| 53 | | Соёлын төвийн дулаан, цэвэр усны шугамыг | Ажлын гүйцэтгэл | 100 хувь | ОНХС 5,0 | 1.Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр дулаан, цэвэр усны шугам солих ажлыг хийж | 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Соёлын төвийн дулаан, цэвэр усны шугамыг сольж шинэчлэх” | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сольж шинэчлэх | | | | гүйцэтгүүлэх | ажлыг “Чандмань”иргэдийн бүлэгтэй 4985700 төгрөгөөр гэрээ байгуулан 150м шугамыг солих ажлыг гүйцэтгүүлж ашиглалтад хүлээж авсан. | |
| 54 | Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцлийг бүрдүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлнэ. | Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулж буй байгууллага, иргэдийг дэмжин ажиллана. | Секц дугуйланд хамрагдсан хүүхдийн тоо<br><br>Улс, бүсийн уралдаан тэмцээнд амжилт гаргасан хүүхдийг урамшуулах | 250-аас доошгүй<br><br>10-аас доошгүй | Хөтөлбөр | 1.3-р сургуулийн мэргэжлийн багш нарын сонгон, секц, дугуйлангуудыг ажиллуулах<br>2.Сумын Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйланд суралцагчдыг хамруулах<br>3.Спортын “Хаялга” клубын секц дугуйланд суралцагчдыг хамруулах | 1. 2018-2019 оны хичээлийн жилд 24 багшийн 29 дугуйлан секцэд давхардсан тоогоор 702 сурагч хамрагдаж байна. 1-5 дугаар ангийн сэтгэх чадварын дугуйланд 260 сурагч, спортын секцэнд 100 сурагч, гар урлал зургийн дугуйланд 45 сурагч, урлагийн дугуйланд 124 сурагч, шатрын дугуйланд 30 сурагч тус тус суралцаж байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулбал дугуйлан, секцэд хамрагдалт 1.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.<br><br>Амжилтуудаас дурдвал: Сэтгэх чадварын олон улсын олимпиадаас 2 хүрэл медаль, 3-р зэргийн диплом 10, 2-р зэргийн диплом 5-ыг тус тус хүртсэн. Мөн аймгийн хөнгөн атлетикийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 мөнгө, 2 хүрэл медаль, аймгийн Монгол бичгийн олимпиадаас 5 сурагч шагналт байранд шалгарсан амжилт үзүүлээд байна.<br>2. Сумын Соёлын төвийн дэргэдэх бүжгийн дугуйланд 2018 онд шинээр 7 хүүхэд элсэн орж нийт 47 хүүхдийн бүрэлдэхүүнтэй хичээллэж байна. 2018 оны 12 сарын байдлаар Шивээн ганхаа бүжгийн хамтлаг нь бүсийн 3 тэмцээнээс 1 алт, 3 мөнгө, 2 хүрэл медаль, улсын тэмцээнээс 1 алт, 1 хүрэл медаль хүртээд байна.<br>3. “Хаялга” спорт клубын сагсан бөмбөгийн дугуйланд 35 сурагч, гар бөмбөгийн дугуйланд 50 сурагч, боксын дугуйланд 18 сурагч, жудо бөхийн дугуйланд 22 сурагч, хөл бөмбөгийн секцэнд 21 сурагч, иргэн Д.Сүхбаатарын 100 буудалт даам, шатрын дугуйланд 40 гаруй сурагч тус тус хамрагдаж | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. 2018 онд гаргасан амжилтуудаас дурдвал: Жудо бөхийн зүүн бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс 2 алт, 4 хүрэл медаль, Боксын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 мөнгө, Өсвөрийн боксчидын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2 хүрэл, 100 буудалт даамны аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс 4 алт, 3 мөнгө, 2 хүрэл медаль, 100 буудалт даамны улсын аварга шалгаруулах тэмцээнээс 1 алт медаль, шатрын аймгийн аварга шалгаруулах тэмцээнээс 1 хүрэл медалийг тус тус хүртээд байна. | |
| **3.3. Хүн ам, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр** | | | | | | | | |
| 55 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийг бууруулна. | Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлж, ажилгүйдлийг бууруулна. | Байнгын ажлын байр<br><br>Түр ажлын байр | 30-аас доошгүй<br><br>50-аас доошгүй | ХЭДС | 1.Сумын АБ, ААН-ээс сул чөлөөтэй орон тооны мэдээллийг маягтын дагуу авч мэдээллийн санд бүртгэх<br>2.Ажилгүй иргэдийг сул чөлөөтэй болон шинээр бий болсон ажлын байранд зуучилж ажлын байраар хангах<br>3.Ажилгүй иргэдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулах | 1. 2018 оны жилийн эцсийн байдлаар Сумын Засаг даргын тамгын газар -7, Шивээ-Овоо ХК-д-82, Ерөнхий боловсролын сургууль-8, Эрүүл мэндийн төвд – 5, Илчлэг Шивээ ОНӨҮГ- 12, Страто ХХК- 13 нийт 127 сул чөлөөтэй орон тооны захиалгыг авч мэдээллийн санд бүртгэсэн.<br><br>2. Сумын ажилгүй 154 иргэний мэдээллийг мэдээллийн санд оруулж 79 иргэнийг түр ажлын байранд 104 иргэнийг байнгын ажлын байранд нийт 182 иргэнийг ажлын байранд зуучилсан байна.<br><br><br><br><br>3. Сумын ажилгүй 8 иргэнийг аж ахуй эрхлэлтийн 3 хоногийн сургалтанд хамруулж аж ахуй эрхлэлтийн төсөл бичих мэдлэгийг олгосон. | 100 |
| 56 | | Иргэдийн эрүүл мэндийн болон | Малчин болон ажилгүй иргэдийг | 30 хувь | - | Иргэдийн даатгалд хамруулах | 2018 онд Эрүүл мэндийн даатгалд 401 иргэн, сайн дурын даатгалд 152 иргэн хамрагдсан | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сайн дурын нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх | эрүүл мэндийн болон сайн дурын нийгмийн даатгалд хамруулсан байна. | | | | байна. Сайн дурын даатгалд оюутан 8, малчин-11, ажилгүй болон хувиараа хөдөлмөр эрхлэгч-133 тус тус хамрагдсан байна. | |
| 57 | Зорилтот бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлэн, ядуурлыг бууруулна. | Зорилтот бүлэгт чиглэсэн аймгийн дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 100 хувь | - | 1. Зорилтот 16 өрхийн судалгааг гаргаж СИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар баталгаажуулах<br><br>2. Зорилтот өрхөд чиглэсэн зорилтот өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах сургалтыг зохион байгуулж төлөвлөгөө гарган ажиллах<br><br>3. Зорилтот өрхийн гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах<br><br>4. Газраа өмчилж аваагүй иргэдийг хуулийн дагуу газартай болгох.<br><br>5. Зорилтот өрхийн 0-18 насны хүүхдүүдийг ЕБС, СӨБ-д бүрэн хамруулах<br><br>6. Зорилтот өрхийн гишүүдийг ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамруулж, түр болон байнгын ажлын байранд зуучлах замаар орлоготой болгох<br><br>7. Зорилтот өрхийн гишүүдийг нийгмийн халамжийн үйлчилгээнд хамруулах<br><br>8. Зорилтот өрхийн гишүүдийг идэвхи санаачлагатай амьдрах сэдлийг төрүүлэх төрөл бүрийн сургалтанд хамруулж нийгмийн оролцоог нэмэгдүүлэх | 1. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 03-р сарын 15-ны өдрийн 11 тоот тогтоолоор Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдах 16 өрхийг батлуулсан.<br><br>2. 2018 оны 03-р сард Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдаж байгаа 16 өрхийн төлөөлөлд “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” сургалтыг зохион байгуулж “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулан ажиллахад заавал хөгжих өрх 2, хөгжлийн төлөөх өрх 12, хөгжлийг дэмжигч өрх 2 байсныг 11-р сарын 20-ны өдөр жилийн эцсийн үнэлгээг хийж заавал хөгжих өрх байхгүй, хөгжлийн төлөөх өрх 9, хөгжлийг дэмжигч өрх 4, хөгжлийг бүтээгч өрх 3 болж өөрчлөгдөн 7 өрхийн түвшин ахисан үзүүлэлттэй байна.<br><br>3. Зорилтот бүлгийн 34 иргэнийг урьдчилан сэргийлэх ДОХ, ХДХВ, Сүрьеэгийн үзлэг шинжилгээнд 2018 оны 10-р сард хамруулсан. Мөн зорилтот 16 өрхийн 80 гишүүнийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.<br><br>4. Газраа өмчилж аваагүй зорилтот бүлгийн 12 иргэнийг хуулийн дагуу өмчлөлийн газартай болгоод байна.<br><br>5. Зорилтот өрхийн 0-18 насны 15 хүүхэд ЕБС-д, 8 хүүхэд, СӨБ-д бүрэн хамрагдаж байна.<br><br>6. Зорилтот өрхийн хөдөлмөрийн насны 45 гишүүний 23 гишүүн нь ажлын байртай болсноос 6 иргэнийг байнгын ажлын байранд, 4 иргэнийг бүлгийн ногоо, 9 иргэнийг нийтийг хамарсан ажилд зуучлан 2205000 төгрөгийн цалинг олгосон. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг олгох ажлын хүрээнд – 1 иргэнд 5 сая төгрөгийг олгож үйл ажиллагаагаа явуулж байна. Ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 7. Зорилтот 16 өрхөөс 4 өрхийн 24 гишүүн 1-7-р сард “Хүнсний эрхийн бичиг”-ийн үйлчилгээнд хамрагдаж байгаад 8-р сараас эхлэн дахин 2 өрхийн 13 гишүүн нэмэгдэж нийт 6 өрхийн 37 гишүүнд 1-11-р сарын 4424000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгосон.<br><br>Нийгмийн халамжийн үйлчилгээнд 27 иргэнийг хамруулан 18939000 төгрөгийг олгосон байна. Мөн Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгч Г.Гэрэлхүү, Л.Гэрэл нар 1-р багийн хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнд “Оргил” рашаан сувилалд сувилуулах зардалд 600.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br><br>8. “Хүнсний эрхийн бичиг”-ийн шиэнчлэгдсэн журам, “Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох”,”Гэр бүлийн аз жаргал”, Гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх тухай хууль”, Нийгмийн халамжийн тухай хуулийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ” зэрэг сэдвээр 6 удаагийн сургалтанд хамруулсан. | |
| 58 | | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн авч ажиллуулсан 25 ба түүнээс дээш ажиллагсадтай ААНБ-ууд | 100 хувь | - | 1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр сумын албан байгууллага аж ахуй нэгжийг мэдээллээр хангах<br>2. Хөдөлмөр эрхэлж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргах<br>3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дутуу ажилуулсан байгууллагаас төлбөрийг сар бүр хураан авч төвлөрүүлэх | 1. 2018 оны 2-р сард Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр сумын албан байгууллага аж ахуй нэгжийн дарга, захирал эрхлэгч нарыг мэдээллээр хангаж ажилласны үр дүнд ерөнхий боловсролын сургууль 2 иргэнийг ажлын байраар хангаад байна.<br>2. Сумын хэмжээнд хөдөлмөр эрхлэж буй 26 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргасан. Үүнд: Засаг даргын Тамгын газарт – 3, Шивээ-Овоо ХК – 17, 3-р цэцэрлэгт – 3, Илчлэг Шивээ ОНӨҮГ-1, ЕБС-2<br>3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дутуу ажиллуулсан Шивээ-Сервис ХХК 864000 төгрөгийг ХЭДС-д төвлөрүүлсэн. Шивээ-Овоо ХК нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн дутуу ажиллуулсны төлбөрийг нэхэмжлэлийн дагуу 2016, 2017 онд ХЭДС-д бүрэн төвлөрүүлсэн тул 2018 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэн дутуу ажиллуулсан төлбөрөөс чөлөөлөгдсөн. | 100 |
| 59 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжсэн бодлого, үйл | “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 100 хувь | ОНХС 5,0 | 1.Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах | Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн төлөвлөгөөний дагуу аян-1, тэмцээн уралдаан-4, сургалт-2, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг-2. соёл урлагийн арга хэмжээ-2 тус тус зохион байгуулж, нийт 40 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг хэрэгжүүлнэ. | | | | | | гаруй хүүхэд залуусыг дэмжиж ажилласан байна. | |
| 60 | | “Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 100 хувь | ОНХС 5.0 | 1.“Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг хангаж ажиллах | “Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг 5 сая төгрөгийн төсөвтэйгээр 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан. | 100 |
| 61 | | Аймгийн нийгмийн салбарт хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ | Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 80-аас дээш хувьтай байна. | - | 1.Хөтөлбөрийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх<br>2.Хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнах | Сумын нийгмийн салбарт аймгийн 5 дэд хөтөлбөр, сумын 2 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр хөтөлбөр тус бүр дээр төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг хангаж ажилласнаар хөтөлбөрүүдийн дундаж биелэлт 94,3 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Боловсролыг дэмжих дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх ажлыг 3 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласнаар 90 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Соёл, урлагийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхээр 3 зорилтын хүрээнд 6 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэнээр 70 хувийн хэрэгжилттэй ажилласан.<br>Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 1 зорилтын хүрээнд 7 ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласнаар 100 хувийн хэрэгжилттэй ажилласан байна.<br>Залуучуудыг дэмжих дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх ажлыг 4 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажилласнаар 100 хувийн биелэлттэй ажилласан.<br>Эрүүл мэндийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхээр 2 зорилтын хүрээнд 10 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласнаар 100 хувийн биелэлттэй байна. | 100 |
| 62 | | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх, “Хамтарсан баг”-ийн үйл | - Хамтарсан багийн ажлын төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг хангаж ажилласан | - Төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь.<br>- Гэр | - | 1.Сумын гэр бүл, хүүхэд хамгааллын Хамтарсан багийн 2018 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах<br>2.Сумын гэр бүл, хүүхэд хамгааллын Хамтарсан багийн 2018 онд хийх ажлын | 1. Сумын гэр бүл, хүүхэд хамгааллын Хамтарсан багийн 2018 онд хийх ажлын төлөвлөгөөг 5 зорилт 17 арга хэмжээг хийж гүйцэтгэхээр төлөвлөсний дагуу төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласнаар 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.<br>2. 2018 оны жилийн эцсийн байдлаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааг тогтмолжуулах | байна. | бүлийн хүчирхийлэл гараагүй байна. | | төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Хамтарсан багийн шуурхай хурлыг 11 удаа зарлан хуралдуулж, шинээр 9 кейс дээр ажилласан. Хамтарсан багийн халамжийн үйлчилгээг 2 иргэнд, холбон зуучлах үйлчилгээг 7 иргэнд үзүүлж, мэргэжлийн сэтгэл зүйчийн зөвлөгөөнд 3 гэр бүлийг хамруулсан. 2017 онд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл бүртгэгдээгүй бөгөөд 2018 онд гэр бүлийн хүчирхийлэл 1, хүүхдийн эсрэг хүчирхийлэл 2 бүртгэгдэж, хуулийн байгууллагад холбон зуучилсан. | |
| **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| **4.1. Байгаль, хүний эрүүл мэндэд ээлтэй ногоон хөгжлийн чиглэлээр** | | | | | | | | |
| 63 | Ногоон бүс, ойн зурвас байгуулах, газрын хөрсийг нөхөн сэргээх замаар байгаль орчны доройтлыг сааруулна. | Сумын нийтийн эзэмшлийн төв талбайн засвар, тохижилт | - Тохижилтын ажлын гүйцэтгэл<br>- Ногоон байгууламжийн хэмжээ | 100 хувь<br>0.1 га | ОНХС<br>1,9 | 1.Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу шууд худалдан авалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулах | Төв талбайн тохижилтын ажлыг ОНХС-ийн 1,9 сая төгрөгийн хөрөнгөөр хийж гүйцэтгүүлэхээр иргэн Г.Золбоотой гэрээ байгуулан төв талбайн саравч, хогийн сав, сандал, гэрэлтүүлэгийг будах, эвдэрсэн зүйлийг засварлах, зүлэгний үр болон усалгааны шланк худалдан авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 64 | | Ногоон байгууламжийн усалгаа, арчилгааг хийх, мод бут тарих | Ажлын гүйцэтгэл | 100 хувь | ОНХС<br>2,0 | 1.Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу шууд худалдан авалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулах<br>2.Шалгарсан гүйцэтгэгчийн ажилд хяналт тавих,тайлагнах | Орон нутгийн хөгжлийн сангийн 2.0 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудын усалгаа, арчилгааны ажлыг “Илчлэг Шивээ” ОНӨҮГ хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд цэцэрлэгт хүрээлэнд 10 улиас, 2 гүйлс, үр, бордоо, хөрс, шланк зэргийг худалдан авч цэцэгжүүлэх ажлыг хийсэн. Мөн бүх нийтээр мод тарих өдрөөр цэцэрлэгт хүрээлэнд нөхөн сэргээлт хийж шинээр 323 мод тарьсан. | 100 |
| 65 | | Хуримтлагдсан хур хог хаягдал, туурь балгасыг цэвэрлэх | Цэвэрлэх талбайн хэмжээ | 2 га | ОНХС | 1. Сумын хэмжээнд байгаа хог хаягдалтай талбайн судалгааг шинэчлэн гаргаж арга хэмжээ авах | Сумын хэмжээний хур хог хаягдал, туурь балгастай талбайн судалгааны ажлыг 10-р сард зохион байгуулж суманд нийт 4,2 га талбай байна.<br>Зориулалтын бус газар хог хаягдал хаяж байсан 2 иргэнийг илрүүлж хогийг төвлөрсөн хогийн цэгт хаяуулсан. Сумын туурь балгас, хур хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийлгэхээр БИНХ-аар хэлэлцүүлэн эрэмбэлүүлээд байна. | 70 |
| 66 | | Хог хаягдлын менежментийг сайжруулж, хог гаргасны төлбөрийг бүрэн | - Сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн орчин нөхцлийг сайжруулах | Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг технологийн дагуу устгах орчин | ОНХС<br>15,0 | 1. Ахуйн хог хаягдал тээвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн хогийг цэвэрлэж булах ажлыг зохион байгуулах<br>2. Нэртийн булаг, Бэхтийн булаг, | 1. 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 15.0 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдлыг тээвэрлэх ажлыг “Илчлэг Шивээ” ОНӨҮГ-тай гэрээ байгуулж хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тогтмол тээвэрлэн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төвлөрүүлнэ. | - Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг зохион байгуулах<br>- Хог гаргасны төлбөрийг бүрэн төвлөрүүлэх<br>- | бүрдсэн байна.<br><br>Иргэн, аж ахуйн нэгжээс гарсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.<br><br>Хог гаргасны төлбөрийг 100 хувь төвлөрүүлсэн байна. | | Хаялага нуур орчмын хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах<br><br>3. Бүх нийтийн их цэвэрлэгээг тогтмолжуулах<br><br>4. Албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хог хаягдал гаргасны төлбөрийг бүрэн төвлөрүүлэх | хүргэж байна. Мөн сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийн дүүрсэн нүхийг булуулж, шинээр 336 м3 нүх ухаж, төвлөрсөн хогийн цэгийг цэвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн.<br><br>2. Нэртийн булаг, Бэхтийн булгийн орчны хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг 5 удаа зохион байгуулж 7 байгууллагын 130 гаруй ажилтан албан хаагчид хамрагдаж 21,4 м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан. Мөн Нийтийг хамарсан ажилд сумын ажилгүй 25 иргэнийг хамруулан Хаялга нуурын ойр орчмын 9 м3 хог хаягдлыг түүж цэвэрлүүлсэн.<br><br>3. Сумын Засаг даргын 2018 оны А/18 тоот захирамжийн дагуу бүх нийтийн их цэвэрлэгээг 14 хоног тутам зохион байгуулж байна. 11-р сарын байдлаар нийтийн их цэвэрлэгээг 15 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 360 албан байгууллага, ААН-ийн 1300 иргэн 270м3 хог хаягдал цэвэрлэсэн байна.<br><br>4. Албан байгууллага, ААН-үүдэд сар бүр хог хаяглын төлбөрийн нэхэмжлэх тарааж хог хаягдал гаргасны төлбөрийг орон нутгийн орлогод төвлөрүүлэн ажилласнаар 11 сарын байдлаар 16500000 төгрөг төвлөрүүлэхээс 9823000 төгрөгийг төвлөрүүлсэн. | 100 |
| 67 | | Хог хаягдлын цэгүүдэд улирал бүр ариутгал хийх ажлыг зохион байгуулах | - Ариутгал хийгдсэн хогийн цэгийн тоо | 5-аас дээш | - | 1. Сумын төвийн хогийн цэгүүдэд ариутгал хийх | Орон сууцнуудын гадна байрлах 5 бункерт улирал бүр ариутгал хийж өнгө үзэмжийг сайжруулан будсан. | 100 |
| 68 | | Зуун умай хөшөө дурсгалыг сэргээн засварлаж хашаажуулах | - Ажлын гүйцэтгэл | 100 хувь | - | 1. Зуун умай хөшөө дурсгалыг сэргээн засварлах ажлыг соёлын төвтэй хамтран зохион байгуулах | Сумын түүх соёлын үл хөдлөх дурсгал болох “Зуун умай” хөшөөний хамгаалалтын хашааг сэргээн засварлаж хөшөө дурсгалын түүхийн талаарх мэдээллийн самбарыг шинээр байршуулан ажилласан. | 100 |
| 69 | Байгаль орчныг хамгаалж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглан, ашиглалтыг сайжруулахад | Байгаль орчны хууль тогтоомжуудыг сурталчилах, байгаль хамгаалах ажилд иргэдийн оролцоог | - Зохион байгуулсан сургалтын тоо | 4 | - | 1. Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах<br>2. Иргэдэд сургалт зохион байгуулж мэдээ мэдээллийг хүргэх | 1. Сумын Нээлттэй хаалганы өдөрлөг, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын нээлттэй хаалганы өдөрлөгүүдээр 4 төрлийн 500 гаруй гарын авлагыг иргэдэд тараасан.<br><br>2. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдэд зөрчлийн тухай хууль, хог хаягдлын тухай хууль, бусад сэрэмжлүүлэх, гарын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | олон нийтийн оролцоог хангана. | нэмэгдүүлнэ. | | | | | авлагыг эргүүл шалгалтын үеэр 164 иргэнд олгосон. Мөн “Хаялга” нуурын зүүн хойно, баруун урд талд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх самбарыг байршуулсан. | |
| 70 | | Байгаль хамгаалах эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулах | - Эргүүл шалгалтын тоо | 6 | - | 1.Аймгийн БОАЖГ, МХГ, ОБГ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран эргүүл шалгалтын ажлыг хуваарийн дагуу зохион байгуулах | Сумын Засаг даргын 2018 оны 06-р сарын 04 өдрийн “Эргүүл шалгалтын ажил зохион байгуулах тухай” А\85 дугаар захирамжаар хаялга нуурын орчимд 6-р сарын 07-ны өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд 10 удаагийн эргүүл шалгалтын ажлыг зохион байгуулж амарч зугаалж байгаа иргэдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг өгч ажилласан. Мөн Аймгийн БОАЖГ, МХГ, ОБГ болон сумын цагдаагийн хэсэгтэй хамтран хөдөөгийн айл өрхүүдээр эргүүл шалгалтын маршрут гарган 5 удаа 1500 гаруй км газарт зохион байгуулж ажилласан. | 100 |
| **4.2. Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгаль хамгаалах ажилд бүх нийтийн оролцоог хангах чиглэлээр** | | | | | | | | |
| 71 | Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, зохистой ашиглана. | Булаг, шанд, уст цэгийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах | Цэвэрлэсэн тайлбайн хэмжээ | 1 га | - | 1. Нэртийн булаг, Бэхтийн булаг, Хаялага нуур орчмын хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах | Нэртийн булаг, Бэхтийн булгийн орчны хог хаягдлыг түүж цэвэрлэх ажлыг 5 удаа зохион байгуулж 7 байгууллагын 130 гаруй ажилтан албан хаагчид хамрагдаж 21,4 м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан. Мөн Нийтийг хамарсан ажилд сумын ажилгүй 25 иргэнийг хамруулан Хаялга нуурын ойр орчмын 9 м3 хог хаягдлыг түүж цэвэрлүүлсэн. | 100 |
| 72 | | Ундны усны эх үүсвэрийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авч, хамгаалалтын горимыг мөрдүүлнэ. | Ажлын гүйцэтгэл | 100 хувь | - | 1.Ундны усны эх үүсвэрийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах газрын СИТХ-аар батлуулах | Сумын ундны усны эх үүсвэр алсын 1, 2-р худгийг ИТХ-ын 2018 оны 12 дугаар тогтоолоор Орон нутгийн тусгай хамгаалалтанд авч, ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэн ажиллаж байна. | 100 |
| 73 | Байгаль орчныг хамгаалж, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглан, ашиглалтыг сайжруулахад олон нийтийн оролцоог хангана. | Бүх нийтээр мод тарих өдрийг зохион байгуулж, мод, тарьсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудыг урамшуулалд хамруулах | Таригдсан модны тоо | 500-аас доошгүй | БТ | 1. “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг зохион байгуулах<br>2.Мод тарьсан иргэдийг урамшуулалд хамруулах<br>3.Иргэн аж ахуйн нэгж байгууллагад сургалт зохион байгуулж иргэдийг мод тарих ажилд оролцуулах | 1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийг хавар, намрын улиралд зохион байгуулж 22 аж ахуйн нэгж, байгууллага сумын төвийн цэцэрлэг хүрээлэн болон өөрийн эзэмшлийн талбайд 9 төрлийн 989 мод шинээр тарьсан.<br>2. 2017 онд өөрийн хөрөнгөөр мод тарьсан 3 иргэний материалыг аймгийн БОАЖГ-т хүргүүлж 2019 оны модны урамшуулалд | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хамруулахаар болсон.<br>3. “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-өөр мод тарьсан иргэдэд мод, зүлэг, мандлын цэцэг тарих заавар зөвлөгөө өгч гарын авлага тарааж ажилласан. Мөн цахим мэдээллийн хэрэгсэлээр иргэдэд хүргэж ажилласан. | |
| **ТАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | |
| **5.1. Захиргаа, хууль эрх зүйн чиглэлээр** | | | | | | | | |
| 74 | Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. | Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | Хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт | 100 хувь | - | 1.Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж батлуулах<br>2. Хэрэгжилтийн хагас бүтэн жилээр тайлагнах | 1. Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулахад чиглэсэн аймгийн дэд хөтөлбөрийг 2018 онд хэрэгжүүлэхээр 2 зорилтын хүрээнд 7 арга хэмжээг төлөвлөн батлуулсан.<br>2. Төлөвлөгөөний хэрэгжилт хагас, бүтэн жилээр хангаж ажилласнаар жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| 75 | | Төрийн албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх нөхцөл, мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулна. | Зохион байгуулсан сургалтын тоо<br>Мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтанд хамруулсан албан хаагчдын тоо | 2-оос доошгүй<br>3-аас доошгүй | - | 1.2018 оны Авлигын эсрэг төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллах<br>2.Авлигын эсрэг төлөвлөгөөг олон нийтэд мэдээллэх, мэдээллийн самбар болон вэб сайтад байршуулах<br>3. Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнах | 1. Авлигын эсрэг төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.<br>2. Авлигын эсрэг төлөвлөгөөг сумын вэб сайт, мэдээллийн самбарт байршуулан иргэдэд ил тод мэдээллэсэн.<br>3. Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнаж 2018 оны жилийн эцсийн байдлаар 96,5 хувьтай хэрэгжсэн байна. | 100 |
| 76 | Төрийн үйлчилгээний ил тод байдлыг ханган, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй, чанартай хүргэнэ. | Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэдэд тайлагнах, иргэдээс санал авч үр дүнг үнэлэх ажлыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах | Санал асуулгад оролцсон өрхийн эзлэх хувь<br>Зохион байгуулсан уулзалт | 10 хувь<br>1-ээс багагүй. | - | 1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг иргэдэд тайлагнах,<br>2. Иргэдээс санал асуулга авч үр дүнг үнэлэн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжилтийг хангаж ажиллах | 1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг ИТХ-ын 2018 оны 08 дугаар тогтоолоор батлуулж сумын вэб сайтад байршуулан ажиллаж байна. Мөн Засаг даргын Тамгын газрын 2017 он, 2018 оны хагас жилийн ажлын тайланг эмхэтгэл болгон бэлтгэж 200 гаруй иргэдэд тарааж ажилласан. Малчдын нэг өдөр өдөрлөгийг зохион байгуулж сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тайланг малчдад тайлагнасан.<br>2. Сумын нээлттэй хаалганы өдөрлөгөөр 112 иргэнээс төрийн үйлчилгээ болон төрийн албан хаагчдын харилцаа, ёс зүй, цаг баримтлалын талаар санал асуулга авч ажиллахад сайн үнлэгдсэн. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 77 | | Байгууллагын цахим хуудсыг тогтмол ажиллуулан, мэдээ мэдээллийг ил тод байршуулж, шинээр зохион байгуулсан ажлаа иргэдэд сурталчлах арга хэмжээ авч ажиллах | – Цахим хуудасны ил тод байдлыг хангаж, мэдээллийг тухай бүрт нь байршуулж хэвших<br>– Иргэдэд мэдээллийг түргэн шуурхай хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | - Байгууллагын үйл ажиллагаа ил тод болсон байна. | - | 1. Засгийн газрын 143 дугаар тогтоолын хэрэгжилтийн хангаж ажиллах<br>2. Байгууллагын цахим хуудсыг тогтмол шинэ мэдээ, мэдээллээр баяжуулах | 1. Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолыг мөрдлөг болгон байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж ажиллаж байна.<br>2. Байгууллагын цахим хуудасны бүтцэд аудитын зөвлөмж болон зөвлөмжийн хэрэгжилтийн цэсийг шинээр нээн нийт 8 цэсэнд холбогдох мэдээллийг байршуулан ажилласан. Сумын цахим хуудасны хандалтын тоо 11-р сарын байдлаар 12000 хэрэглэгч хандсан байна. | 100 |
| 78 | | Хууль тогтоомж сурталчлах ажлыг зохион байгуулах. | – Сургалт, сурталчилгааны тоо | - 12 | - | 1. 2018 онд зохион байгуулагдах “Нээлттэй хаалга”-ны хуваарь гарган батлуулж хуваарийн дагуу улирал бүр зохион байгуулах<br>2. Иргэдэд зохион байгуулах сургалтын төлөвлөгөө гарган батлуулж төлөвлөгөөний дагуу сургалтыг сар бүр зохион байгуулах<br>3. Дотоод эрх зүйн сургалт зохион байгуулах төлөвлөгөө гарган батлуулж төлөвлөгөөний дагуу сургалтыг сар бүр зохион байгуулах<br>4. Шинээр батлагдсан болон шинэчлэн өөрчлөгдсөн хууль тогтоомжуудаар гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэх | 1. “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгийг аймгийн хэлтэс агентлагуудтай хамтран 3 удаа, сумын аж ахуй нэгж, албан байгууллагуудтай хамтран 2 удаа зохион байгуулж нийт 1283 иргэнд үйлчилгээ үзүүлэн 2977 гарын авлага тарааж, 12 санал, хүсэлт, өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэн ажилласан.<br>2. Иргэдэд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг гарган батлуулж төлөвлөгөөний дагуу сургалтыг 16 удаа зохион байгуулж 975 иргэн хамрагдсан байна.<br>3. Дотоод эрх зүйн сургалтыг 2018 онд зохион байгуулах төлөвлөгөөг гарган батлуулж төлөвлөгөөний дагуу сургалтыг 13 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 240 ажилтан, албан хаагч хамрагдсан байна.<br>4. Шинээр батлагдсан болон шинэчлэн өөрчлөгдсөн 11 хуулиар гарын авлага бэлтгэж Нээлттэй хаалганы өдөрлөг болон багийн иргэдийн нийтийн хурал, аялах хайрцаг зэрэг арга хэмжээнүүдийн үеэр 1330 иргэдэд олгон ажилласан байна. | 100 |
| 79 | | Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэж хариу мэдэгдэх; | Өргөдөл, гомдлыг 15 хоногийн хугацаанд шийдвэрлэх.<br>Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь<br>Хариутай бичгийг | – 100 хувь | - | 1. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг 15 хоногийн хугацаанд шийдвэрлэх.<br>2. Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлэн хэлэлцүүлгийн тэмдэглэлийн хамт холбогдох газарт хүргүүлэх<br>3. ЗДТГ-т 2018 онд ирсэн | 1. 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт нийт 1145 өргөдөл ирсэнээс 1131 өргөдлийг 15 хоногийн хугацаанд шийдвэрлэж 7 өргөдлийг 30 хоногийн хугацаанд, газар хүссэн 3-н өргөдлийн хугацааг 30 хоногоор сунган шийдвэрлэж 4 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна.<br>2. Улирал бүр өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтийн мэдээ, тайланг сумын Засаг даргын зөвлөлийн хуралд тайлагнан аймгийн Төрийн захиргааны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хугацаанд нь шийдвэрлэх. | | | хариутай бичгийг хугацаанд нь шийдвэрлэх | удирдлагын хэлтэст хүргүүлсэн.<br>3. ЗДТГ-т 2018 оны 12 дугаар сарын 05-ны байдлаар 773 албан бичиг ирсэнээс хариутай албан бичиг – 253 байна. Ирсэн хариутай 253 албан бичигт хяналтын карт хөтөлж, хяналт тавин 243-г хугацаанд нь шийдвэрлэж, 10 албан бичгийн хугацаа болоогүй, шийдвэрлэгдэх шатандаа байна. | |
| 80 | | Багийн иргэдийн нийтийн хурлыг зохион байгуулах | Зохион байгуулагдах хурлын тоо Хамрагдсан өрхийн хувь | 3 Багийн нийт өрхийн 53 хувь | - | 1.Багийн иргэдийн нийтийн хурлыг улирал бүр зохион байгуулах | 1, 2 багийн иргэдийн нийтийн хурлыг 5-р сард зохион байгуулж 2018 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2019 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын санал, сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийн гишүүнийг сонгох зэрэг асуудлыг хэлэлцэж нийт өрхийн 60 –аас дээш хувийг хамруулсан. | 40 |
| 81 | | Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх шаардлагатай техник хэрэгсэл, программаар хангах | Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын хувь<br>Удирдлагын баримтуудыг сканердаж цахим сан үүсгэх<br>Архивын программ хангамжийг суурилуулж холболтын ажлыг хийх<br>Шаардлагатай техник хэрэгсэлээр хангах | - 20<br>- Цахим хэлбэрт шилжүүлсэнээр иргэн, байгууллага цахим сангаас мэдээлэл авахад хялбар болсон байна. | - | 1. Архивын баримтын 20 хувийг цахим хэлбэрт шилжүүлэх<br>2. Архивын цаасан суурьтай баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж, удирдлагын баримтуудыг скайнердаж цахим сан үүсгэх<br>3. Шаардлагатай техник хэрэгслээр хангах | 1. Байгууллагын архивт хадгалагдаж буй 2001-2017 оны байнга, 70 жил хадгалах нийт 44 захирамж, тушаалыг архивын программд бүрэн оруулж цахим хэлбэрт шилжүүлсэн.<br>2. Байгууллагын архивт хадгалагдаж буй удирдлагын 2001-2017 онуудын байнга, 70-н жил хадгалах цаасан суурьтай баримтанд иж бүрэн нягтлан шалгалт хийж, скайнердан, цахим сан үүсгэсэн.<br>3. Албан хэрэг хөтлөлтийн нууц хадгалах, хамгаалах цоожтой шүүгээгээр ханган ажиллаж байна. | 100 |
| **5.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр** | | | | | | | | |
| 82 | Иргэдийн амгалан тайван, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ. | Ãàì ø ãèéí ýðñäëýýñ óðüä÷èëàí ñýðãèéëýõ î ëî í í èéòèéã õàì àðñàí àðãà õýì æýýã àâ÷ хэрэгжүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2-оос доошгүй | ОНХС 0,5 | 1.Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх<br>2.Гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх олон нийтийг хамарсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.<br>3.Үлийн цагаан огтоно устгах ажлыг зохион байгуулах | 1. Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>2. Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолын дагуу “Газар хөдлөлтийн дуут дохио”-гоор ажиллах дадлага сургуулилтыг зохион байгуулж сумын 13 аж ахуйн нэгж, байгууллага, 1, 2-р багийн нийт 847 иргэн, 56 авто машин хамрагдсан. Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын дагуу нүүлгэн шилжүүлэх ажилд 56 автомашины бэлэн байдлыг хангаж ажилласан. Сумын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-ний дагуу “Газар хөдлөлтийн тухай ойлголт, дуут дохиогоор ажиллах заавар” сэдэвт сургалтыг иргэдийн | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дунд зохион байгуулж 21 иргэн хамрагдсан. Мөн ОНХС-ийн 250000 төгрөгийн хөрөнгөөр “Хаялга” нуурын зүүн хойно, баруун урд талд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх самбарыг байршуулсан.<br>3. Бэлчээрт тандалт судалгаа хийж сумын нутаг дэвсгэрийн оготно мэрэгч ихтэй газрын байршлыг тогтоож ОНХС-ийн 1 сая төгрөгийн хөрөнгөөр 10 цэгийн 12 га газар, Улсын төсвийн 3,2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 8 цэгийн 2000 га газарт тус тус хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг энгийн, механик, биологийн аргаар зохион байгуулж ажилласан. | |
| 83 | | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, архидан согтуурахтай тэмцэх ажлыг зохион байгуулах. | Төлөвлөгөөний хэрэгжилт | - 100 хувь | БТ | 1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулах<br>2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний дагуу сумын байгууллагуудтай хамтран ажиллах<br>3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр гаргаж тайлагнах | 1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 12 арга хэмжээг хийж гүйцэтгэхээр төлөвлөн батлуулж хэрэгжилтийг ханган ажилласан.<br>2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сумын цагдаагийн хэсэг, аймгийн хуулийн байгууллагуудтай хамтран ажиллаж зөрчлийн тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулиудыг 200 гаруй иргэнд сурталчилж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.<br>3. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг улирал бүр сумын ИТХ-д тайлагнан ажилласан. | 100 |
| 84 | | Сумын төвийн золбин нохой устгах | - Ажлын гүйцэтгэл | - 100 хувь | ОНХС 1,0 | 1.Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу шууд худалдан авалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулах<br>2.Шалгарсан гүйцэтгэгчийн ажилд хяналт тавих,тайлагнах | 1. Нохой устгалын ажлыг 2018 оны Орон нутгийн хөгжлийн сангийн 1 сая төгрөгийн хөрөнгөөр хавар, намрын улиралд зохион байгуулж нийт 64 нохой, 13 муурыг устгаж ариутгал халдваргүйтэлийг хийж булсан.<br>2. Нохой устгалын ажилд 1-р багийн засаг дарга, байгаль хамгаалагч нар өдөр бүр хяналт тавьж, гүйцэтгэлийг байгууллагын удирдлагуудад тайлагнан ажилласан. | 100 |
| 85 | | Цэргийн бүртгэл, Цэрэг татлагыг зохион байгуулах, цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэдэд сургалт явуулах, мөнгөн төлбөрийн | Тогтоосон хугацаанд зохион байгуулж, хяналтын тоог биелүүлсэн байна. | 100 хувь | - | 1. Цэргийн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулах<br>2. Цэргийн насны залуучуудад зарлан дуудах хуудсыг тарааж, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагаас тогтоосон хяналтын тоонд багтаан хугацаат цэргийн албаны татлагыг зохион байгуулах<br>3. Цэргийн насны залуучуудын шилжилт хөдөлгөөнд хяналт | 1. Сумын Засаг даргын 2017 оны 12-р сарын 01-ний өдрийн А/126 тоот Захирамжаар цэргийн шинэчилсэн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж сумын хэмжээнд нийт 910 иргэн хамрагдахаас 750 иргэн хамрагдаж 82,4 хувьтай бүртгэгдсэн байна.<br>2. Цэрэг татлагын ажлыг 2 удаа зохион байгуулж цэргийн насны 126 иргэн хамрагдаж цэрэг татлага 72,2%-ийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тооцоо хийх. | | | | тавих<br><br>4. Цэргийн жинхэнэ албаа хаах хугацаа дуусгаж ирсэн иргэдийг ажлын байранд зуучлах ажлыг зохион байгуулах<br>5. Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзолыг хангасан иргэдийн төлбөр төлөх ажлыг зохион байгуулах<br><br>6. Цэргийн насны болон өсвөр насны иргэдийн дунд эх оронч үзэл, хүмүүжил олгоход чиглэсэн 3-аас доошгүй арга хэмжээг зохион байгуулах | 3. Цэргийн насны залуучуудын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллан 3 иргэн шилжсэнийг аймгийн цэргийн штабт мэдэгдэн шилжүүлж ажилласан.<br>4. 2017 онд цэргийн алба хааж ирсэн 3 иргэний 2 нь мал маллаж 1 нь ажилгүй байна.<br>5. Цэргийн дүйцүүлэх албыг 6 иргэн мөнгөн төлбөрийн хэлбэрээр хаах болзолыг хангаж, уг иргэдийн төлбөр төлөх ажлыг зохион байгуулсан.<br>6. Сумын 18-26 насны залуучуудад Цэргийн албаны тухай хуулиар сургалт зохион байгуулж 43 иргэн хамрагдсан. Мөн Цэргийн албаны тухай хууль, Батлан хамгаалах тухай хуулиудаар гарын авлага бэлтгэж 200 гаруй иргэнд тарааж ажилласан. | |
| 86 | | Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах; | - Зохион байгуулагдсан сургалтын тоо | - 4 | - | 1. Батлан хамгаалах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг иргэдэд сурталчилах<br>2. Цэргийн бэлтгэл сургалтанд сум, багийн Засаг дарга нарыг хамруулах. | 1. Сумын 18-26 насны залуучуудад Цэргийн албаны тухай хуулиар сургалт зохион байгуулж 43 иргэнийг хамруулсан. Мөн Цэргийн албаны тухай хууль, Батлан хамгаалах тухай хуулиудаар гарын авлага бэлтгэж 200 гаруй иргэнд тарааж ажилласан.<br>2. Энэ жил сум, багийн Засаг дарга нарт зориулсан сургалт зохион байгуулагдаагүй болно. | 70 |

## БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО

| д/д | Зорилт | Арга хэмжээний тоо | Үүнээс | | | | Үнэлэх боломжгүй | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 биелсэн | Хэрэгжих шатандаа | | | | |
| | | | | 70% | 40% | 0% | | |
| 1. | **5** | **86** | **67** | **15** | **2** | **-** | **2** | **93,2** |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

НЗЭЗАХМ О.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.ЦЭВЭЭНДУЛАМ